МАНАЙ СОНИНЫ III УЛИРЛЫН НЭМЭЛТ ЗАХИАЛГА ЯВАГДАЖ БАЙНА

MMINFO.

19 дэх жилдээ

МОНГОЛЫН МЭДЭЭ

Хүн ам 3,148.887... ҮСХ-ны өгөгдлийн мэдээгээр

2017.06.20. Мягмар. №119 (4733) ӨДӨР ТУТМЫН АНХНЫ ЧӨЛӨӨТ ХЭВЛЭЛ Худалдах үнэ 500 төг

УЛС ТӨР

Ж.ЭРДЭНЭБАТ: МОНГОЛ УЛС ХӨРӨНГӨ ОРУУЛАГЧДЫГ УРИН ДУУДАЖ БАЙНА

II нүүрт

ДЭЛХИЙ

Э.МАКРОНЫ ЯЛАЛТ ҮРГЭЛЖИЛСЭЭР...

VI нүүрт

Улаанбаатарт: ӨНӨӨДӨР

Өдөр +20
Шөнө +10

Дугаарын 60 мөр

Бид нэг л монголчууд

Б.ТОГТОХ

Ерөнхийлөгчийн сонгуулийн албан ёсны сурталчилгаа 10 гаруй хоног үргэлжилж, энэ долоо хоногт дуусах шатандаа орж байна. Албан бус болон албан ёсны сурталчилгааны хугацааг нийлүүлээд тооцвол сар гаруйн хугацаанд бид гурван хүний талаар сайнаасаа илүү саар мэдээллийг хангалттай сонсч үзлээ. Ёстой л нэгэн иргэний халагласан шиг орчлонгийн хамгийн муу, бузар булай гурван хүн Ерөнхийлөгчид өрсөлдөж байгаа аятай л хар бараан мэдээллээр өдөр шөнөгүй бөмбөгдүүлж байна. Тэр ч байтугай нэр дэвшигчийн хийж буй ажил, эрхэлж байсан бизнес, ар гэр лүү нь хүртэл дайралтаа явуулж байна, пиарчид.

Үргэлжлэл нь III нүүрт

Улирсан баларсан үеийн тогтолцоог өөрчлөөч, Г.ЧУЛУУНБААТАР ГУАЙ

Б.ДАВААХҮҮ

ЕБС-ийн төгсөх ангийн сурагчдын ЭЕШ /элсэлтийн ерөнхий шалгалт/ орон даяар энэ сарын 14-ний өдөр Монгол хэл, бичгийн шалгалтаар эхэлж, өнгөрөгч ням гарагт Нийгмийн тухай мэдлэг, физик, орос хэлний хичээлийн шалгалтаар өндөрлөлөө. Энэ жил 40388 шалгуулагч бүртгүүлснээс хөдөө орон нутагт 22889 шалгуулагч ЭЕШ-аа өгөх байв. Гэвч гурван сурагч бүртгүүлсэн атлаа шалгалтаа өгч чадсангүй. Учир нь тэд аймгийн төвд очиж, шалгалтаа өгөх ёстой гэсэн боловсролын салбарын арилж өгдөггүй хуучин тогтолцооны дагуу замын унаанд дайгдаж явахдаа авто осолд орж, хорвоог орхижээ. Тэднийг аав ээж нь автобусанд суулгасан ч найзынхаа төрсөн өдрийг тэмдэглээд автобуснаасаа хоцорсон тэд замын таксинд сууж яарч явахдаа ийн харамсалтайгаар амиа алдсан гэх мэдээлэл ч гарч байгаа юм. Хэрэг өнгөрөгч долоо хоногт гарсан. Тэд Дорноговь аймгийн Замын-Үүд сумын сурагчид байсан бөгөөд ирээдүйн мэргэжлээ сонгохоор аймгийн төв рүүгээ давхиж яваад ийн осолд оржээ. Таван хүүхэд осолд орсноос гурав нь жолоочийн хамт амиа алджээ. Тэдний хүсэл мөрөөдөл хэчнээн гэгээн байсан бол.

Үргэлжлэл нь III нүүрт



ОНЦЛОХ МЭДЭЭ

Гадаад дахь Монголчуудын саналыг СЕХ-нд хүлээлгэн өглөө

Хилийн чанадад ажиллаж, амьдарч буй Монголчуудын саналыг авах үйл ажиллагаа энэ сарын 10, 11-нд болсон билээ. Тэгвэл өчигдөр гадаад улсад байгаа иргэдийн санал авах ажлыг зохион байгуулах Төв комисс гадаад улсад саналаа өгсөн сонгогчдын бүртгэлийн дүгнэлтийг хийсэн саналын хуудсыг Сонгуулийн Ерөнхий Хороонд хүлээлгэн өглөө. Сонгуулийн тухай хуульд заасны дагуу Сонгуулийн Ерөнхий Хороо гадаад улсад саналаа өгсөн сонгогчдын санал тоолох ажиллагааг өөрийн байранд санал авах өдрийн 22:00 цагт эхлүүлж, ажиглагч, хэвлэл, мэдээллийн байгууллагын төлөөлөгчийг байлцуулан бүтүүмжилсэн дүгнэлтийг нээж, саналыг хуудсыг санал тоолох төхөөрөмжид хийж саналыг тоолж дүнг гаргана гэж СЕХ-ны хэвлэл, мэдээллийн төлөөлөгч мэдээлэв. Гадаад улсад байгаа иргэдээс сонгуульд оролцож саналаа өгөхөөр 7209 иргэн бүртгүүлж тэдгээрээс 4816 иргэн буюу 66.8 хувь нь саналаа өгсөн билээ.

АЛБАНЫ ХҮНИЙ ҮГ

Д.ДАВААДОРЖ: “Тогтвортой бичил уурхай” төслийн бичил уурхай дахь сайн туршлагууд журам шинэчлэгдэхэд их үр дүн өгсөн

Бичил уурхайгаар ашигт малтмал олборлох журам шинэчлэгдэн батлагдсантай холбогдуулан Уул уурхай, хүнд үйлдвэрийн яамны Бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын дарга Д.Даваадоржтой ярилцлаа.

-Бичил уурхайгаар ашигт малтмал олборлох журам шинэчлэгдэн батлагдлаа. Энэ талаар дэлгэрэнгүй мэдээлэл өгөхгүй юу?

-Засгийн газрын 2010 оны 308 дугаар тогтоолоор Бичил уурхайгаар ашигт малтмал олборлох журмыг анх баталсан байдаг. Гэвч энэхүү журам хэрэгжих явцад зарим зохицуулалт дутуу, тэр бүрчлэн амьдралд нийцэхгүй зэрэг эргэж хармаар хүндрэлтэй асуудлууд олон гарснаар журмын хэрэгжилт төдийлөн хангагдахгүй байсан. Журмыг шинэчлэн батлах эрх зүйн болон практик хэд хэдэн шаардлага байсны дагуу Үндэсний хэмжээний хэлэлцүүлэг, чуулганууд зохион байгуулж, тэндээс гарсан санал, зөвлөмжийг нэгтгэж 2017 оны тавдугаар сард Засгийн газрын 151 дүгээр тогтоолоор шинэчлэн батлаад байна.

-Тухайлбал, ямар өөрчлөлтүүд орсон бэ?

-Дээрх хэлэлцүүлэг, чуулганаас гарсан санал, зөвлөмжид тоног төхөөрөмжийн болон бичил уурхайгаар ашигт малтмал олборлох талбайн асуудлууд гол төлөв хөндөгдөж байсан бөгөөд энэ асуудлуудыг одоогийн нөхцөл байдалд хэрхэн нийцүүлж сайжруулахад анхаарал хандуулж ажилласан. Бид тоног төхөөрөмжийн хүчин чадлыг долоо дахин ихэсгэсэн, гэхдээ энэ нь зөвхөн Иргэний хуулийн 35 дугаар зүйлд заасан нөхөрлөл, мөн хуулийн 36.4-т заасан хоршооны хэлбэрт орсон хуулийн этгээд ашиглаж болохоор зааж өгсөн. Энэ нь цаашид хууль бусаар ашигт малтмал олборлогчдыг албажуулан хуулийн хүрээнд ажиллах нөхцөлийг нь бүрдүүлнэ гэж үзэж байна.

Үргэлжлэл нь VII нүүрт

ХААН банк

	Авах	Зарах		Авах	Зарах
АМ.ДОЛЛАР	2355.00	2372.00	ФУНТ	2964.00	3066.00
ЕВРО	2609.00	2669.00	РУБЛЬ	39.90	42.10
ИЕН	21.08	21.46	ЮАНЬ	344.00	348.60

Худалдаа хөгжлийн банк

	Авах	Зарах		Авах	Зарах
АМ.ДОЛЛАР	2355.00	2370.00	ФУНТ	2978.00	3055.00
ЕВРО	2608.00	2677.00	РУБЛЬ	39.88	42.88
ИЕН	20.97	21.55	ЮАНЬ	345.00	348.40

Өчигдрийн 19.00 цагийн байдлаар

УЛС ТӨР

МЭДЭЭЛЭЛ

Хар машинд ямар нэг но илрээгүй гэв

“Шударга сонгуулийн төлөө иргэний нийгмийн сүлжээ”-ний гишүүн МИДАС ТББ-аас өчигдөр сонгуулийн санал тоолох автоматжуулсан систем буюу хар машины талаар мэдээлэл хийлээ. “Шударга сонгуулийн төлөө иргэний нийгмийн сүлжээ”-ний гишүүн МИДАС ТББ нь 2012 оноос эхлэн сонгуульд санал тоолох автоматжуулсан системийг нэвтрүүлснээс хойш УИХ-ын болон Ерөнхийлөгчийн сонгуульд хөндлөнгийн хяналт, мониторинг хийж иржээ. Энэхүү хугацаанд автоматжуулсан системийн найдвартай ажиллагааг сайжруулах чиглэлээр зөвлөмж гарган мониторингийн тайландаа тусгаж ирсэн ба тэдгээрийн ихэнхийг СЕХ хүлээн авч дараа дараагийн сонгуулийн бэлтгэл ажилдаа хэрэгжүүлж ирсэн гэв. Тус байгууллагын зүгээс хар машиныг зөвхөн зайнд залгаж ажиллуулж, машины цаг хугацааг өөрчилж уншуулах, хэвлэсэн билл дээрх мэдээллийн ойлгомжтой байдлыг шалгах, үр дүнгийн билл хэвлэсний дараа модем холбож үр дүнг дамжуулах, хоёр CF буюу компакт дискэнд мэдээллүүдийг хооронд нь жиших, CF дискнээс зурган файлыг СД рүү бичих зэрэг туршилт хийж шалгахад алдаа илрээгүй хэмээн мэдэгдлээ. Мөн өнгөрсөн сонгуулиар хяналтын буюу техникийн тооллогыг нийт санал хураах байрны 50 хүртэл хувьд нь хийсэн боловч саналын тоо зөрсөн тохиолдол гараагүйг онцоллоо. Энэ удаагийн хөндлөнгийн мониторингийг хийхдээ илүү тэмдэглэгээтэй саналын хуудсыг төхөөрөмж уншихгүй болсон программын нэмэгдэл өөрчлөлттэй уялдуулан тестийн тавил боловсруулсан бөгөөд логик, нягт нямбай байдлын тест хийжээ. Энэхүү тестийн дүн нь хүлээлэгдэж байсан үр дүнтэйгээ тохирсон аж.

MMINFO.

МОНГОЛЫН МЭДЭЭ

19 дэх жилдээ

Ерөнхий эрхлэгч: С.ГАНТОГОО

Орлогч эрхлэгч Ч.ЧУЛУУНЦЭЦЭГ 99189158

Хариуцлагатай нарийн бичгийн дарга: Э.ЭНХЦЭЦЭГ 90873012

Ахлах редактор: Б.ӨНӨРТОГТОХ 88006842

Шуурхай мэдээлэл, эрэн сурвалжлах алба Н.ПУНЦАГБОЛД 88096454

Улс төр, гадаад мэдээлэл, эдийн засгийн алба: Б.ӨНӨРТОГТОХ 88006842

Гэрэл зургийн алба: Г.АРГУУЖИН 96017873

Компьютерийн алба: Б.ГАНЗОРИГ 99998796

Маркетинг, зар сурталчилгааны алба: Н.АЛТАНЦЭЦЭГ 99173710

Захиалга, борлуулалтын алба: М.ДАВААДУЛАМ 99042510

Э.САЙНЗАЯА 99197866

Дугаарыг эрхэлсэн Б.ӨНӨРТОГТОХ

Улсын бүртгэлийн дугаар: 907300528
Индекс: 100757

Редакцийн хаяг:
Улаанбаатар хот. Сүхбаатар дүүрэг. Чөлөөт хэвлэл сан /Хэвлэлийн хүрээлэн/. 2 давхар. 209, 211 тоот

“Монголын мэдээ” сонины редакцид эхийг бэлтгэж, “Чөлөөт хэвлэл сан”-ийн хэвлэх үйлдвэрт хэвлэв.

ОНЦЛОХ ҮЙЛ ЯВДАЛ

Ж.ЭРДЭНЭБАТ: МОНГОЛ УЛС ХӨРӨНГӨ ОРУУЛАГЧДЫГ УРИН ДУУДАЖ БАЙНА

Б.ТОГТОХ

Монголын Бизнесийн Зөвлөл (МБЗ)-ийн хоёрдугаар чуулга уулзалт “Азийн бүс нутгийн эдийн засгийн уялдаа холбоо” сэдвийн дор Их Тэнгэр цогцолборт өчигдөр боллоо. Энэхүү чуулга уулзалтад 250 орчим олон улсын болон дотоодын төр засгийн төлөөлөгч, хөрөнгө оруулагч, бизнес эрхлэгчид оролцсон юм. Тэд бүс нутгийн бизнесийн хөгжлийн харилцан үр ашигтай түншлэлтэй холбоотой дэд бүтэц, эрчим хүч, уул уурхайн төслүүдийг хэлэлцэхээс гадна бүс нутгийн уялдаа холбоог сайжруулснаар бий болох эдийн засгийн хөгжлийн боломжуудын талаар санал солилцлоо. Монголын эдийн засаг, бизнесийн өрсөлдөх чадвар нь дэд бүтэц, зам тээвэр, эрчим хүчний салбарын хөгжлөөс шууд хамааралтай байдаг. Тиймээс хоёрдугаар чуулга уулзалтын үеэр “Бүс нутгийн эдийн засгийн уялдаа холбоо: Эдийн засгийн шаардлагаас улс төрийн бодлого руу”, “Зүүн хойд Азийн эрчим хүчний нэгдсэн сүлжээ”, “Азийн дэд бүтцийн хөрөнгө оруулалтыг шийдвэрлэх нь”, “Байгаль орчин дахь бүс нутгийн бизнесийн чиг хандлага” гэсэн дөрвөн гол сэдвийн хүрээнд салбар хуралдааныг зохион байгуулж, хэлэлцүүлгийг өрнүүлэв. Мөн чуулга уулзалтын үеэр гурван илтгэл тавигдсан бөгөөд “Бүс нутгийн эрчим хүчний зах зээлийг өргөжүүлэх нь” сэдвийн хүрээнд Япон Софт Банк Энержи Корпийн Тэргүүн дэд ерөнхийлөгч Шигэки Мива, “Азийн дэд бүтцийн хөрөнгө оруулалт” Азийн хөгжлийн банкны Монгол дахь суурин төлөөлөгчийн газрын Ахлах эдийн засагч Деклан Мэги, “Байгаль орчин, нийгэм, засаглал дахь бүс нутгийн бизнесийн чиг хандлага” сэдвийн хүрээнд “Эрдэнэ Ресурс”-ын тусгай зөвшөөрөл хариуцсан Дэд Ерөнхийлөгч Жон Лионз нар илтгэл тавьсан юм. Мөн энэхүү чуулганд Ерөнхий сайд оролцож улсын эдийн засаг болон хөрөнгө оруулалтын орчин, гадаадын хөрөнгө оруулалтыг хэрхэн нэмэгдүүлэх талаар байр сууриа илэрхийлэв. Өөрөөр хэлбэл, УИХ-аас батлагдсан “Эдийн засгийг сэргээх хөтөлбөр” амжилттай хэрэгжиж байгааг онцолж, ОУВС-ийн “Өргөтгөсөн санхүүжилтийн хөтөлбөр”-т хамрагдсанаар эдийн засаг тогтворжиж сэргэх хандлагатай болсон хэмээв. Түүнчлэн, Монгол Улсын зээлжих зэрэглэл буцаад тогтвортой гэсэн төвшиндээ хүрч, Монгол Улс хөрөнгө оруулагчдыг урин дуудаж байна гэв. Ерөнхий сайд Ж.Эрдэнэбат хэлсэн үгэндээ “Монгол орон эрдэс түүхий эдийн арвин их нөөцтэй, хөрөнгө оруулагчдын сонирхлыг татсан улс. Манай улсын гадаад худалдааны эргэлт жилээс жилд өсөн нэмэгдэж 2016 оны байдлаар 8.3 тэрбум ам.долларт хүрсэн бол энэ оны эхний таван сарын байдлаар 4.0 тэрбум ам.доллартай тэнцлээ. Нийт экспортын 80 гаруй хувийг уул уурхайн бүтээгдэхүүний экспорт эзэлж байна. Цаашид эдийн засгаа төрөлжүүлж, олон тулгууртай болгох, хөдөө аж ахуйн түүхий эдээ эцсийн бүтээгдэхүүн болгон боловсруулж, дэлхийн зах зээлд худалдах хэтийн зорилго тавин ажиллаж байгаа. Далайд гарцгүй Төв Азийн олон улс орны нэгэн адил Монгол Улс ч гэсэн гадаад худалдааны дэд бүтцээ хөгжүүлэх, тээвэрлэлтийн хурдан шуурхай, хямд өртөгтэй шинэ суваг бий болгох, бүс нутгийн худалдааны сүлжээнд нэгдэн орох хүсэл эрмэлзэлтэй байна. БНХАУ-ын нийслэл Бээжин хотноо өнгөрсөн сард болсон “Нэг бүс, Нэг зам” сэдэвт уулзалтад миний бие улсаа төлөөлөн оролцож улс орнуудын хамтын хүчин чармайлтаар бүс нутагт худалдаа, тээвэрлэлтийн нэгдсэн сүлжээг хөгжүүлэх, түүнд Монгол Улсын оруулж болох хувь нэмрийн талаар байр сууриа илэрхийлсэн билээ. Мөн энэ сарын эхээр ОХУ-д болсон “Санкт Петербургийн Эдийн засгийн форум”-ын хүрээнд ч бүс нутгийн худалдаа, эдийн засгийн хамтын ажиллагаа, хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэх арга замын талаар олон улс орны бизнес эрхлэгчид болон холбогдох албаны хүмүүс хэлэлцсэн” хэмээгээд цаашдаа хоёр хөрштэйгээ хийж байгаа гадаад худалдааг өргөжүүлэхийн тулд чамгүй олон ажил хийхээр төлөвлөснөө танилцуулав. Тухайлбал, Монгол Улсаар дамжин өнгөрөх бүх төрлийн тээвэрлэлт, худалдааг цаашид улам нэмэгдүүлэх асар их боломж байгаа гэж үзсэн учраас, энэхүү боломжоо ажил хэрэг болгохын тулд Азийн хөгжлийн банкны “Бүс нутгийн хамтын ажиллагааг хөгжүүлэх төсөл”-ийн хүрээнд баруун бүсэд транзит тээвэрлэлтийг хийх боломжийг бүрдүүлсэн хатуу хучилттай авто замыг барьж дуусгаж онцлов. Мөн Алтанбулаг-Замын-Үүд чиглэлийн төмөр замын тээх, нэвтрүүлэх чадварыг жил ирэх тутам өргөтгөн сайжруулж байгаа, өнгөрсөн жилүүдэд тасалдаад байсан ОХУ-аас БНХАУ-д нийлүүлэх газрын тосны бүтээгдэхүүний төмөр замын тээвэрлэлт дахин сэргэж эхэлсэн таатай мэдээг энэ үеэр чуулганд оролцогчдод дуулгасан юм. Цаашид дамжин өнгөрөх төмөр замын тээвэрлэлтийг нэмэгдүүлэх, эрчим хүчний нэгдсэн сүлжээ байгуулах, хоолойн тээвэрлэлтийг хөгжүүлэх чиглэлээр ОХУ, БНХАУ болон бүс нутгийн бусад улс оронтой үр ашигтай санаачилга, төслүүдийг хэрэгжүүлэхэд Монгол Улс идэвхтэй хамтран ажиллах сонирхолтой байгаа гэдгийг Гүйцэтгэх засаглалын тэргүүн хэлсэнүгэндээонцоллоо. Засгийн газраас батлагдсан “Хөгжлийн зам хөтөлбөр” нь БНХАУ-ын “Торгоны замын эдийн засгийн бүс” санаачилга болон ОХУ-ын “Евразийн эдийн засгийн холбоо” хамтын ажиллагааны механизмтай уялдуулан гурван улсыг хамарсан “Эдийн засгийн коридор” байгуулах хөтөлбөрийг хэрэгжүүлэхтэй уялдуулж гаргасан том хэмжээний хөтөлбөр гэдгийг ч чуулганд оролцогчдод танилцууллаа. Өчигдрийн чуулга уулзалтад “Токио Мицибуши”, “Софт” банк болон бусад томоохон хөрөнгө оруулагчийн төлөөлөл оролцож байгаад Ерөнхий сайд тун ч олзуурхаж байсан юм. Харин “Азийн бүс нутгийн эдийн засгийн уялдаа холбоо” чуулга уулзалтыг зохион байгуулсан Монголын Бизнесийн Зөвлөлийн ТУЗ-ийн дарга Б.Бямбасайхан “Монголын Бизнесийн Зөвлөл нь хөрөнгө оруулалт, худалдаа, бизнест таатай орчин бүрдүүлэхэд чиглэсэн үйл ажиллагаа явуулж, Монгол Улсын эдийн засгийн хөгжилд өөрийн гэсэн бодит хувь нэмэр оруулахыг зорьж ажилладаг. Энэ ч утгаараа Монгол болон олон улсад зохион байгуулагддаг тэргүүлэх төвшний хөрөнгө оруулалтын чуулга уулзалтуудыг зохион байгуулж ирсэн. Одоогоор дэлхийн 100 гаруй улс “Нэг бүс, нэг зам” санаачилгыг дэмжихээ илэрхийлж, үүнээс 40 гаруй улс хамтын ажиллагааны гэрээнд гарын үсэг зурж, түншлэхээ мэдэгдсэн. Энэ санаачилгыг монголын компаниуд хэрхэн бизнесийн боломж болгох вэ, яаж бодит ажил болгон хэрэгжүүлэх вэ гэдэг талаар, түүнчлэн Азийн бүс нутагт ямар боломжууд байгаа, ирээдүйд ямар боломжууд бий болох талаар хэлэлцэж, мэдээлэл солилцохыг энэ удаагийн чуулган маань зорилоо. Монголын компаниуд Азийн бүс нутагт уялдаа холбоогоо сайжруулна гэдэг ирээдүйд бизнес хийхэд илүү өрсөлдөх чадвартай болно гэсэн үг” хэмээн байр сууриа илэрхийлэв.

> ...Энэ санаачилгыг монголын компаниуд хэрхэн бизнесийн боломж болгох вэ, яаж бодит ажил болгон хэрэгжүүлэх вэ гэдэг талаар, түүнчлэн Азийн бүс нутагт ямар боломжууд байгаа, ирээдүйд ямар боломжууд бий болох талаар хэлэлцэж, мэдээлэл солилцохыг энэ удаагийн чуулган маань зорилоо...

МЭДЭЭ, МЭДЭЭЛЭЛ

Телевиз болон тараах материалд нэр дэвшигчид хоёр тэрбумыг зарцуулжээ

“Шударга сонгуулийн төлөө иргэний нийгмийн хяналт сүлжээ”-ний гишүүн байгууллага болох “Глоб интернэшнл төв” болон “Бодлогод залуусын хяналт” ТББ-аас өчигдөр 2017 оны Ерөнхийлөгчийн сонгуулийн сурталчилгааны үеэр телевизүүдэд хийгдсэн мониторингийн талаар хэвлэлийн бага хурал хийлээ. Иргэний нийгмийн байгууллагуудаас Ерөнхийлөгчийн 2017 оны сонгуулийн сурталчилгаанд телевизийн мониторинг хийж Сонгуулийн тухай хууль болон СЕХ, ХХЗХ-ноос хамтран баталсан журмын хэрэгжилтэд хяналт тавин ажиллаж байгаа юм байна. Телевизийн мониторингд MYOHT, TV9, 25 дугаар суваг, C1, UBS гэсэн таван телевизийг хамруулахаар сонгожээ. Дээрх телевизүүдийг сонгохдоо Хэвлэлийн хүрээлэн, Максима ХХК-ны 2016 оны судалгаанд суурилж, олон нийтийн санхүүжилт ашигладаг, хамгийн хүртээмжтэй, орон даяар цацагддаг, агаарын долгион ашигладаг, үзэгчдийн тоо, рейтинг өндөр, цаг үеийн мэдээний хөтөлбөр нэвтрүүлдэг, зах зээлд 4-өөс дээш жил оршин тогтносон, нэр дэвшигчийн хамаарал зэрэг шалгуурыг үндэслэсэн байна. Телевизэд зарцуулсан мөнгөн зардлын талаар “Бодлогод залуусын хяналт”ТББ-ынГүйцэтгэхзахирал Ц.Мандхайхатан мэдээлэл өглөө. Тэрбээр “Улс төрийн намууд сонгуулийн хугацаанд шилэн данстай байж, сонгуулийн кампанит ажлын зарцуулалтаа ил тод, олон нийтэд мэдээлэх ёстой. Гэхдээ өнөөдрийг хүртэлх хугацаанд ямар нэгэн мэдээлэл, тайлангаа ил тод болгож тавиагүй байна. Өнгөрсөн хугацаанд улс төрийн намууд санхүүгийн ямар зардлууд гаргах гэж байгааг бид баримтжуулах гэж оролдож байна. C1, 25 дугаар суваг, UBS, TV9 телевизүүдийн Сонгуулийн Ерөнхий Хороонд хүргүүлсэн үнийн санал дээр тулгуурлаж ерөнхий дундаж зардлыг гаргалаа. Энэ гэхдээ хатуу зүйл биш бидэнд ирүүлсэн мэдээллийг үндэслэн гаргасан тоо юм. Ямар ч байсан өнгөрсөн ес хоногийн хугацаанд хэвлэл, мэдээлэлд нэг тэрбум орчим төгрөгийг гурван нэр дэвшигч зарцуулсан гэдэг ерөнхий тооцоо хийлээ. Мөн айл, өрхүүдээр тарааж өгч буй хэвлэмэл материалын зардал дунджаар нэг удаагийнх нь нэг тэрбум төгрөг болж байна. Нийт хоёр тэрбумыг одоогоор гаргаад байна” гэв. Мөн энэхүү таван телевизийн нийт эфирийн долоон хувийг сонгуультай холбоотой мэдээлэл эзэлж байна хэмээлээ.

Сонгуулийн өдөр архи, согтууруулах ундаагаар үйлчлэхгүй

Нийслэлийн удирдах ажилтны ээлжит шуурхай зөвлөгөөн боллоо. Энэ үеэр Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагч С.Батболд “Хуурайшилт ихтэй байгаатай холбоотойгоор обьектийн болон ой хээрийн түймрийн аюулаас урьдчилан сэргийлэх талаар тодорхой арга хэмжээ авч ажиллах, хүүхдийн зуслангийн үйл ажиллагаа эхлэх гэж байгаатай холбогдуулан хүүхдүүдийг тээвэрлэх, хоолны хүнсний болон гал түймрийн аюулгүй байдалд онцгой анхаарч урьдчилан сэргийлэх арга хэмжээ авч ажиллах хэрэгтэй” гэв. Түүнчлэн холбогдох албан тушаалтнуудад үүрэг даалгавар өглөө.

Монгол Улсын Ерөнхийлөгчийн ээлжит сонгууль зохион байгуулах бэлтгэлийг хангах ажлын хүрээнд:

- Санал авах байр болон хуульд заасан бусад шаардлагатай зүйлсийг сонгуулийн төв байгууллагаас баталсан зааврын дагуу хуулийн хугацаанд бэлэн болгох,
- Санал авах өдөр согтууруулах ундаагаар үйлчлэх, худалдах,
- Соёл, урлаг, үзвэр, спортын зэрэг олныг хамарсан аливаа арга хэмжээ зохион байгуулах,
- Гадаа болон битүү талбайд худалдаа үйлчилгээний төв ажиллуулах зэрэг хуулиар хориглосон үйл ажиллагааг зогсоож, хяналт тавьж ажиллахыг дүүргийн Засаг дарга нар болон холбогдох албан тушаалтнуудад үүрэг болгов.

Сонгуулийн өдрүүдэд:

- Нийслэлийн иргэдийн амгалан тайван байдлыг хангах, хулгайн болон бусад гэмт хэрэг зөрчлөөс урьдчилан сэргийлэх, хэв журмыг сахиулж ажиллах,
- Замын хөдөлгөөний аюулгүй байдлыг хангаж, замын хөдөлгөөний ачаалал ихтэй уулзваруудад зохицуулагч ажиллуулах,
- Нийтийн тээврийн үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлэн иргэдийг хүндрэлгүй зорчих нөхцлийг бүрдүүлэхийг холбогдох албан тушаалтнуудад үүрэг болголоо.

ҮЗЭЛ БОДОЛ

Дугаарын 60 мөр

Бид нэг л монголчууд

Үргэлжлэл.
Түрүүч нь I нүүрт

Сонгуулийн сурталчилгаа эхэлсэн хоёр долоо хоногийн хугацаанд хамгийн их дуулиан тарьсан сэдэв бол МАН-ынхан төрийн албан тушаалыг арилжиж 60 тэрбум төгрөг босгохоор ярилцаж буй бичлэг. Г.Доржзодов гэх залуугийн гаргаж тавьсан энэ бичлэгийг тойроод л сайн муу, саар мэдээлэл өдөр өнжихгүй дуулдаж байна. Хэргийн гол нь тэр нэг залууд биш төрийн албыг арилжихаар ярьсан нь хүн бүрийн эгдүүцлийг төрүүлж байгаа юм. Харин энэ асуудлаас үүдэн МАН-ын залуу генсек Д.Амарбаясгалан "Г.Доржзодовыг хэн нэгэн жүдоч очоод цохиж, амь насанд нь халдчихвал манай нэр дэвшигчийг гэж бодох нийгмийн сэтгэлзүйг бэлтгэчихлээ. Тиймээс бид цагдаагийн байгууллагаас хамгаалалт хүссэн" хэмээн мэдэгдсэн юм. Угтаа энэ үгээрээ тэрбээр Монголын жүдо бөх, цаашлаад дэлхий дахины жүдогийн тамирчдыг "алуурчин", гудамжны танхай этгээд, хүн зодож явдаг хүмүүс мэтээр ярьж ёстой л ам руугаа алгадууллаа. Ам алдсан бол барьж болохгүй, агт алдсан бол барьж болдог гэгчээр Д.Амарбаясгалангийн энэ үг олон мянган хүний дургүйцлийг төрүүлсэн юм. Монголын жүдочид шиг олимпийн дэвжээнд улсынхаа далбааг өргөж, төрийн дууллаа эгшиглүүлсэн нь хэд билээ. Сонгуулийн дуулианаас үүдэж таван сайхан залуу амиа алдсан тэртээх 2008 оны долдугаар сарын 1-ний хар бараан өдрүүдийн дурсамжийг анхны олимпийн алтан медалийг жүдогийн тамирчин Н.Түвшинбаяр авчирснаараа арилгаж байлаа.

Монголчууд тэр өдөр эргэн эвлэлдэж, гуниг, айдсаа баяр хөөрөөр сольж байв. Үүнээс хойшхи амжилтыг дурьдаад байвал цаг хүрэхгүй, цаас ч багадах биз. Дэлхийн аваргууд ээлж дараалан төрж, олимпийн медалийн буухиа ч тэр хэрээр тасарсангүй. Манай тамирчид монголчуудаа олимп, дэлхийн тэмцээн бүрээр баярлуулж, олон олон шинэ амжилтыг дэлхий дахинд тунхаглаж байна. Тэдний хийсэн үйл хэрэг, гавьяа улс төрийн жижигхэн сонгуулиас ч түм бум дахин их байгаа. Ерөнхийлөгчид өрсөлдөж байгаа хүн тэдний холбоог удирдаж, энэ амжилтад хөтөлсөн байлаа гэвэл тэд хэн нэгний захиалгаар, эсвэл сайн дураар хүн очиж зодох нь юу л бол. Тэдэнд ийм ёсзүй, хүмүүжил байхгүй гэдгийг монголчууд бүгд мэднэ. Гэтэл улс төрийн бохир асуудалд жүдочдын нэрийг хамаатуулж, өрсөлдөгчөө дайрах гэж өөрийн нэр дэвшигчээ баллаж орхисон түүнийг зэмлэх хүн олон байсан билээ. Жүдо бөхийн холбооноос ч мэдэгдэл гаргаж, түүнийг уучлалт гуйхыг шаардсан. Тэгвэл шаардлагыг хүлээн авч Д.Амарбаясгалан жудочдоос уучлал гуйлаа. Хэдийгээр бухимдал, дургүйцлээ буруу аргаар илэрхийлж, үгийн сонголтдоо алдаа гаргасан ч хийсэн үйлдэлдээ гэмшсэнд нь талархал илэрхийлье. Залуу хүний дэврүүн араншингаар хэлчихсэн түүний үгийг монголчууд нэг удаад уучлах нь дамжиггүй. Д.Амарбаясгалан генсек ч алдаанаасаа суралцаад үлдлээ. Улстөрч болох гэж бэлтгэгдэж байгаа залуус ч энэ удаагийн жишээнээс суралцана биз. Буруу газар, буруу цагт хэлсэн үг ямар хор хөнөөлтөйг, цаашлаад буруу хэлсэн үгэндээ хариуцлага хүлээж чаддаг байхын чухлыг энэ үйл явдал давхар харуулж өгөв. Сонгууль мөнх үргэлжлэхгүй. Маргааш гэхэд л дуусч, нар гардгаараа л гарна. Тэр цагт эргэж уулзах нүүртэй байхсан. Бид нэг л монголчууд.

Улирсан баларсан үеийн тогтолцоог өөрчлөөч, Г.ЧУЛУУНБААТАР ГУАЙ

Үргэлжлэл.
Түрүүч нь I нүүрт

Ирээдүйд сайн хуульч, эсвэл сайн багш, магадгүй сонирхлоо дагаад хөлбөмбөгчид ч болох байсан юм билүү. Гэсэн ч, золгүй байдлаар гурван мөрөөдөл, гурван хүсэл эздийнхээ хамт хорвоогоос буцлаа. Гурван ээж халуун нулимсаа урсгаж, гурван гэр бүл хагацлын гашууныг мэдэрлээ. Тэдний үхэлд хэн буруутай вэ. Цэл залуухан, бүр дурлаж ч үзээгүй хүүхдүүдийн амины төлөөсийг хэнээс нэхэж, бас бурууг хаанаас эрэх хэрэг вэ. Шалгалтын материал задарсан гэх хэргээр Боловсрол соёл, шинжлэх ухаан, спортын сайд Ж.Батсуурь огцорч, түүний оронд Г.Чулуунбаатар томилогдоод удаагүй байна. Гэтэл хүүхдийн амь эрсэдсэн байхад хэн хариуцлага хүлээх нь өнөө хэр асуулт дагуулсан хэвээр байх юм. Сонгуулийн бараан мэдээлэл дунд гурван хүүхдийн харамсалтай үхэл дарагдаад өнгөрөх бололтой. Ингэж боломгүй байлтай. Тестийн хариу задрахад огцруулж болдог атлаа хүний амь эрсэдчихээд байхад хэнд ч хариуцлага тооцдоггүй гажиг тогтолцоо ганцхан манай улсад л байдаг биз.

Осол гол шалтгаан биш

Уг нь Хүүхэд хамгааллын тухай хуульд хүүхдүүдийг аюулгүй тээврийн хэрэгслээр тээвэрлэх ёстой гэж заасан байдаг юм билээ. Тэгвэл ослын тухайд салбарын шинэ сайд Г.Чулуунбаатар "Энэ харамсалтай золгүй хэргийн талаар бүх мэдээлэл тодорхой байгаа. Хариуцлагын асуудал яригдана. Хэн гэгч албан тушаалтан, байгууллага хариуцлага хүлээх ёстой вэ гэдэг асуудал яригдах нь тодорхой. Замын-Үүдээс 193 хүүхэд элсэлтийн шалгалтад орох тоотой байсан. Осолд орсон таван хүүхдээс бусад 110 нь галт тэргээр, 48 хүүхэд нийтийн тээврээр, 30 хүүхдийг эцэг эх нь өөрсдөө Сайншандад хүргэсэн байгаа юм. Тэр таван хүүхдийн хувьд өөрсдөө зохион байгуулж нийтийн тээврийн үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрөлтэй таксигаар үйлчилгээ авч яваад осолдсон юм билээ. Тэгэхээр үүнтэй холбогдуулж хариуцлагын тухай асуудал хуулийн дагуу шийдэгдэнэ. Одоо бол шалтгаан нөхцлийг нь судлах, шалгах ажил явагдаж байна. Хариуцлага хүлээх шаардлагатай албан тушаалтан мэдээж гарч ирнэ, тэр хүлээх ёстой" гэж мэдэгдсэн байх юм. Ямартай ч, хэн нэгэн албан тушаалтан хариуцлага хүлээх нь. Гэвч, гол асуудлыг нь орхигдуулаад байна. Ганц энэ удаад л хүүхэд амиараа хохирсон юм биш. 330 сумын сурагчид Элсэлтийн ерөнхий шалгалтаа өгөхөөр аймгийн төв рүүгээ яваад осолд өртөх явдал мэдэгдэхгүй өнгөрөх тохиолдол ч цөөнгүй байдаг гэх. Их бага хэмжээгээр тэд эрсдэл туулж, ирээдүйн мэргэжлээ эзэмших шалгалт өгөхөөр явж байна. Урин дулаан улиралд хэдхэн км замыг туулахад сүртэй юм хэмээн өмгөөлж болох ч эдгээр хүүхдүүдэд зам тээврийн осол аваараас гадна, аймагт байрлах, хооллож ундлах асуудал ч төвөгтэй байдгийг өөрийн биеэр мэдэрч явснаа нуух юун. Аймагтаа ах дүү, танил талгүй бол шалгалт дуусах хүртэл буудалд байрлах гэх мэтээр эдийн засгийн хувьд ч асар их чирэгдэл үүсдэг. Эцэг эх нь дагаж ирэхээр мөн л тодорхой хэмжээний зардал гарна. Шинжлэх ухаан өдрөөс өдөрт хөгжиж, манай улсын бүхий л сумд интернэт сүлжээнд холбогдчихлоо. Гэтэл Боловсролын системд тогтсон элсэлтийн шалгалт авах тогтолцоо 30, 40 жилийн өмнөх тэр үеэс ер өөрчлөгдсөнгүй, ахиц дэвшил ч алга. Социализмын үед л их дээд сургуулийн хуваарь авах гэж тэвштэй ногоон машинтай аймгийн төв рүүгээ давхидаг байлаа. Өнөөдөр ч энэ хэвээр. Машин нь олон төрөл болсноос биш тогтолцоонд ер өөрчлөлт гараагүй байх юм. Үүнийг өөрчлөөч, сайд гуай. Хэчнээн хүүхэд амиа алдаж, хэдэн гэр бүл хагацал үзэх ёстой гэж. Монголын Боловсролын салбар хэчнээн сурагчийн амиар "туг тахиж" байж, энэ тогтолцоог өөрчлөх юм бол. Одоогоос олон жилийн өмнө Ховд аймаг руу ЭЕШ өгөхөөр сумаасаа гарсан хоёр хүүхэд мөн л автын ослоор амиа алдаж байв.

Тусгаар улсын хүн амтай тэнцэх хүүхдүүд эрсдэл туулсаар...

Улсын хэмжээнд энэ жил ЭЕШ-ын 49 байр бэлдсэний 27 нь нийслэлд, 22 нь аймгуудад бий. Тэгвэл хялбархан тоо бодъё. Энэ жилийн тухайд нийт 40388 сурагч элсэлтийн Ерөнхий шалгалт өгсөн. Нэг сумаас хамгийн багадаа 50 хүүхэд аймгийн төвд очиж шалгалтаа өгнө гэж тооцвол бүхэл бүтэн тусгаар тогтносон улсын хүн амтай тэнцэхүйц хэмжээний сурагч осолд өртсөн гурван сурагчийн адил аймгийн төвөө бараадан шалгалтаа өгөх болдог. Ингэж хэлбэл, дэгдүүлсэн хэмээн буруутгаж мэдэх. Гэхдээ Номхон далайн Элисийн арлуудад багтдаг тусгаар тогтносон Тувалу арал улс 10 гаруй мянган хүн амтай гэнэ билээ. Тэгэхээр бүхэл бүтэн нэг улсын хүн амтай тэнцэх, магадгүй түүнээс хоёр дахин их тооны ахлах сургуулийн сурагчид замын унаанд дайгдан төвөө бараддаг байх нь. Элсэлтийн Ерөнхий шалгалтын материалыг битүүмжилсэн байдаг. Сүүлийн жилүүдэд шалгалтын материалын битүүмжлэл алдагдаж, материал задарсан гэх дуулиан гарах болсон. Энэ жил ч гэсэн ийм асуудал дэгдэж, салбарын сайд нь хүртэл суудлаасаа буусан билээ. Шалгалтын материалын хариу задарсан гэх дуулиан өнгөрсөн жил ч гарч байлаа. Тухайн үед Боловсролын үнэлгээний төвөөс ЭЕШ-ын материал задрах, нууцлал алдагдах боломжгүй гэж мэдэгдэж байв. Үнэхээр шалгалтын материал задрах, нууцлал алдагдах боломжгүй юм бол сумын сургуульд нь ЭЕШ-ыг авч болохгүй гэж үү. Сумын багш нарт итгэхгүй байж мэдэх л юм. Ах дүү амраг садны холбоо сүлбээнээс ч эмээдэг байж мэдэх. Үнэхээр тийм бол яамнаасаа нэг төлөөлөл томилчихвол асуудал шийдэгдчих юм биш үү. Интернэт, техник технологи хоног тутамд хөгжиж байхад, 21 аймгийн 330 суманд тус бүр нэг шалгалтын байр гаргахад юу нь болохгүй гэж. Үгүй ядахдаа, ойролцоо сумдыг нэгтгээд бүсчилж авахад ч болохгүй гэх зүйл алга. Замын-Үүд суманд шалгалтын байр хэрэв гаргасан бол гурван хүүхэд нас барж, хоёр хүүхэд "эрэмдэг" болохгүй л байлаа. БСШУС-ын шинэхэн сайд Г.Чулуунбаатар хэн нэгэнд хариуцлага тооцохоо мэдэгдсэн тухай дээр дурьдсан билээ. Гэхдээ энэ зөвхөн Замын-Үүдийн асуудал биш юмаа, сайд аа. Бүх сумын төгсөх ангийн сурагчдад жил бүр тохиолддог нийтлэг асуудал нь энэ. Өөрийн эрх мэдлийн хүрээнд салбарын тогтолцооны асуудлаа шийдээгүй байж, хурд хэтрүүлсэн такси, хулгайгаар тээвэрт явсан иргэнд хариуцлага тооцлоо гээд яах ч билээ. Бартаатай зам байсаар байгаа цагт осол аваар хэлж ирэхгүй хийсч ирэх нь тодорхой. Тиймээс эхлээд ЭЕШ-аа орон нутагт нь авдаг болчих. Ингэж өөрчилвөл амиа алдах сурагчдын тоо үүгээр дуусах биз ээ. Энд амиа алдсан хөвгүүдийг буруутгах гэсэнгүй. Гагцхүү тэдний үхэл зүгээр нэг хариуцлагагүй жолоочийн буруу болоод өнгөрөхгүй байгаасай гэсэндээ жишээ болголоо. Хүсэл мөрөөдөл чинь тэнгэрт биелж, хүнд сурталгүй илүү сайн сайхан нийгэмд төрж, хүссэн мэргэжлээ сонгоорой хэмээн олон мянган уншигчдынхаа өмнөөс тарни шивнэе. Ум сайн амгалан байх болтугай.

> ...Өөрийн эрх мэдлийн хүрээнд салбарын тогтолцооны асуудлаа шийдээгүй байж, хурд хэтрүүлсэн такси, хулгайгаар тээвэрт явсан иргэнд хариуцлага тооцлоо гээд яах ч билээ. Бартаатай зам байсаар байгаа цагт осол аваар хэлж ирэхгүй хийсч ирэх нь тодорхой. Тиймээс эхлээд ЭЕШ-аа орон нутагт нь авдаг болчих. Ингэж өөрчилвөл амиа алдах сурагчдын тоо үүгээр дуусах биз ээ...

АЙЛЧЛАЛ

Монгол Улстай аялал жуулчлалын салбарт хамтарч ажиллах боломжтой гэв

БОАЖ-ын сайд Д.Оюунхорол БНХАУ-ын Аялал жуулчлалын яамны Аялал жуулчлалын Хэрэг эрхлэх газрын дарга Ли Жин Жао тэргүүтэй төлөөлөгчдийг хүлээн авч уулзлаа. Монгол, Хятад, Орос гурван улсын аялал жуулчлалын сайд нарын уулзалт маргааш Улаан-Үд хотноо эхэлнэ. Энэ хүрээнд БНХАУ-ын Аялал жуулчлалын яамны Аялал жуулчлалын Хэрэг эрхлэх газрын дарга Ли Жин Жао тэргүүтэй төлөөлөгч Монгол Улсад хүрэлцэн ирсэн юм. Төлөөлөгчдийг Д.Оюунхорол сайд хүлээн авч уулзаад "Цайны зам" олон улсын аялал жуулчлалын холбооны хүрээнд хил орчмыг хөгжүүлэхээр Монгол, Хятад, Орос гурван улсын аялал жуулчлалын сайд нарын 2017 оны уулзалт маргааш Улаан-Үд хотноо үр дүнтэйгээр эхэлнэ гэж найдаж байна. Ирэх сарын 22-нд Монгол Улсад Монгол, Хятадын аялал жуулчлалын бүтээгдэхүүнийг сурталчлах өдрүүд болно. Монгол Улс хөрш орнуудтайгаа хил орчмын аялал жуулчлалыг хөгжүүлэх талаар анхаарч ажиллаж байгаагийн тод жишээ нь "Цайны зам" олон улсын аялал жуулчлалын холбоонд нэгдэн орсон явдал юм. Тиймээс манай улсын зүгээс БНХАУ-тай аялал жуулчлалын төв байгуулах, энэ чиглэлийн хүний нөөцийг бэлтгэх, солилцох тал дээр хамтарч ажиллах сонирхолтой байна" хэмээлээ. Үүний хариуд БНХАУ-ын Аялал жуулчлалын яамны Аялал жуулчлалын Хэрэг эрхлэх газрын дарга Ли Жин Жао "Монгол Улстай манай улс хамтарч ажиллах бүрэн боломжтой. "Цайны зам" олон улсын аялал жуулчлалын холбооноос гаргаж буй шийдвэрүүд Монгол, Хятад, Орос гурван улсын хил орчмын аялал жуулчлалыг хөгжүүлэхэд томоохон түлхэц өгнө гэдэгт найдаж байгаа. Энэхүү уулзалтаас гаргасан шийдвэр нь Шанхайн хамтын ажиллагааны байгууллагын шийдвэрт нөлөөлөхүйц байна гэдэгт итгэж байна. Хятад улс "Нэг бүс, нэг зам"-ын хүрээнд ирэх есдүгээр сард олон улсын аялал жуулчлалын сайд нарын уулзалтыг зохион байгуулж, дэлхий нийтээр аялал жуулчлалыг хэрхэн хөгжүүлэх талаар ярилцахаар болсон. Энэхүү томоохон хэмжээний уулзалтаар тухайн улс аялал жуулчлалын бүтээгдэхүүнээ дэлхий нийтэд сурталчлах боломж олдох юм. Тиймээс БОАЖ-ын сайд Д.Оюунхорол таныг энэхүү дэлхийн аялал жуулчлалын салбарынхан хуран чуулах уулзалтад хүрэлцэн ирэхийг урьж байна" гэлээ.

ЗӨВЛӨХ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ТУХАЙ ЗАРЛАЛ

1. Нийслэлийн Худалдан авах ажиллагааны газар нь "Улаанбаатар хотын гудамж замын өндөржилтийн төлөвлөлт 20855.5 га /БЗД, СБД, ЧД-ийн суурьшлын хэсэг/ 20855.5 га" НХААГ-17/0154 дугаартай ажлыг хэрэгжүүлэх зорилгоор зөвлөх үйлчилгээний гэрээ байгуулах гэж байгаа тул зөвлөхийн үйлчилгээ үзүүлэх хүсэлтэй этгээдийг мэдүүлгээ ирүүлэхийг урьж байна.
2. Энэхүү зөвлөх үйлчилгээ нь Нийслэлийн хот төлөвлөлт, ерөнхий төлөвлөгөөний газраас 2017 онд хийгдэх болно.
3. Мэдүүлгээ ирүүлж буй зөвлөх нь уг үйлчилгээг гүйцэтгэх чадвартайг нотлох дараахи мэдээллийг ирүүлнэ:
   - Аж ахуйн нэгжийн улсын бүртгэлийн гэрчилгээний хуулбар
   - Тусгай зөвшөөрлийн хуулбар:
   - Барилга хот байгуулалтын яамны Геодези, зураг зүйн тусгай зөвшөөрөл
   - Тус ажлыг хийж гүйцэтгэх инженер техникийн ажилтны дэлгэрэнгүй мэдээлэл, CV
   - Сүүлийн 3 жилд /2014, 2015, 2016 он/ хийж гүйцэтгэсэн ижил төстэй ажлын жагсаалт, дэлгэрэнгүй мэдээлэл

Чадварыг нэмэгдүүлж сайжруулах зорилгоор зөвлөхүүд түншлэлийн хэлбэрээр оролцож болно.

Тендерийн материалыг Цахим худалдан авах ажиллагааны систем (www.tender.gov.mn) хаягаар өөрийн ААН-ийн хувийн нууцлалын кодыг ашиглан нэвтэрч цахим хэлбэр (pdf)-ээр илгээнэ.Цахим систем ашиглан илгээх нийт файлын хэмжээ 100 Mb, нэг файлын хэмжээ 15 Mb байна. Цахим тендер шалгаруулалт зохион байгуулах журмын дагуу тендерт оролцох хураамж 50,000 төгрөгийг www.tender.gov.mn-ээр банкны меркантийн системийг ашиглан төлнө.

4. Сонирхсон этгээд нэмэлт мэдээллийг 2017 оны 06 дугаар сарын 20-ны өдрийн 08:00 цагаас 2017 оны 06 дугаар сарын 29-ний өдрийн 17:00 цаг хүртэл авч болох бөгөөд Цахим Худалдан авах систем (www.tender.gov.mn)-ээр 2017 оны 06 дугаар сарын 30–ны өдрийн 11:00 цагийн дотор ирүүлнэ үү.

Чингэлтэй дүүрэг, Багатойруу-15, Самбуугийн гудамж,
Нийслэлийн Засаг захиргааны 4 дүгээр байр, 10 давхар,
Нийслэлийн Худалдан авах ажиллагааны газар,
1011 тоот. Утас: 75757810

НИЙГЭМ

Аймгаас мэдээлж байна

ГОВЬСҮМБЭР АЙМАГ

Бага ангийн багш нар "STEM" боловсролын чиг хандлагад суралцлаа

Боловсрол, Соёл, Шинжлэх ухаан, Спортын яамнаас Боловсролын чанарын шинэчлэл төслийн хүрээнд STEM боловсролын чиг хандлага, 21 зууны цогц чадамж, олон улсын туршлага, Монголын бага боловсролд хэрэгжүүлэх хэрэгцээ, шаардлагыг таниулах зорилгоор "STEM боловсролыг бага ангийн сурагчдад эзэмшүүлэх арга зүй" сэдэвт сургалтыг Говьсүмбэр аймагт зохион байгууллаа. Уг сургалтад тус аймгийн таван сургуулийн бага ангийн нийт 60 багш хамрагджээ. Сургалтаар STEM боловсролын мэдлэг, Artec, Fischertechnik хэрэглэгдэхүүнүүдтэй танилцаж хэрэглэх чадвартай болох, бага боловсролын сургалтын цөм хөтөлбөрүүдээр олгох чадварууд ба STEM боловсролын интеграц зэргийн мэдлэг, мэдээллийг хүргэсэн байна.

ДАРХАН-УУЛ АЙМАГ

Дарханы Засаг дарга нэг өрхийн амьдралыг бодитоор өөрчиллөө

Дархан-Уул аймгийн Засаг дарга С.Насанбат долоо хоног бүрийн баасан гарагт иргэдтэйгээ ганцаарчилж уулздаг уламжлалтай. Энэхүү уулзалтын үеэр Дархан сумын Малчин багийн харьяат Эрдэнэ-Очирын Мөнхцэцэг өөрийн гэсэн газартай болох хүсэлтийг тавьсны дагуу өчигдөр биеллээ олжээ. Мөнхцэцэг нь хэдийгээр Малчин багийн харьяат боловч Дархан сумын нэгдүгээр багт айлын хашаанд амьдардаг бөгөөд 7-16 насны дөрвөн хүүхэдтэй өрх толгойлсон, халамжид байдаг эмэгтэй ажээ. Тус эмэгтэйд туслах үүргийг аймгийн Засаг дарга Хөрөнгө оруулалт хөгжлийн бодлого төлөвлөлтийн хэлтэст үүрэг болгосон байна. Энэ дагуу тус хэлтсийн харьяанд байдаг агентлагууд нэгдэн энэхүү эмэгтэйд тусалж байна. Төрийн байгууллагууд нэгдэн хамтын хүчээр өрх толгойлсон эмэгтэйд тусалж Дархан сумын нэгдүгээр багийн пионерийн 14 дүгээр гудамжны 88 тоотод суух албан ёсны хаягтай болголоо. Өрх толгойлсон эмэгтэйд туслах ажилд Хөрөнгө оруулалт хөгжлийн бодлого төлөвлөлтийн хэлтэс, БОАЖГ, ГХБХБГ, Ус цаг уур орчны шинжилгээний алба, Стандартчилал хэмжил зүйн хэлтэс, Дархан хот байгуулалт барилга захиалагчийн газар, Дархан зам тээвэр, ХХААГ, Янжмаа захиралтай Хангай захын захиргаа, иргэн Отгонсүрэн нар хамтран гэр бүлийн хэрэгцээнд зориулалттай 627 м2 талбайтай өмчлөлийн газрын гэрчилгээг олгохын зэрэгцээ хашааг барьж өгсөн юм.

ДОРНОГОВЬ АЙМАГ

Эрүүл мэндийн үзлэг, оношилгоонд 1176 иргэн хамрагдав

"Элэг бүтэн Монгол" үндэсний хөтөлбөрийн өдөрлөгийн хүрээнд Эрүүл мэндийн яамны Төрийн нарийн бичгийн дарга Д.Очирбат Дорноговь аймагт ажиллалаа. Энэ үеэр Халдварт өвчин судлалын үндэсний төв, Хавдар судлалын үндэсний төв, Улсын III төв эмнэлэг, Геронтологийн үндэсний төв, Арьсны өвчин судлалын үндэсний төв, АШУҮИС болон "Гранд мед эмнэлэг"-ийн нарийн мэргэжлийн эмч нар иргэдэд үнэ төлбөргүй үзлэг оношилгоо хийжээ. Үзлэгт оношилгоонд нийт 1176 иргэн хамрагдсанаас сүрьеэгийн сэжигтэй тохиолдол тав, шинээр оношилогдсон хавдрын тохиолдол 11, хавдрын дахилттай тохиолдол хоёр, хавдрын үсэрхийлэлтэй тохиолдол нэг, элэгний С вирүстэй тохиолдол 13, элэгний В вирүстэй 10 илэрчээ. Өвчний тохиолдол илэрсэн иргэдэд дээрх эмнэлгүүд болон аймгийн Нэгдсэн эмнэлгээс эмчилгээнд хамруулах юм. Мөн өдөрлөгийн хүрээнд Дорноговь аймгийн Засаг даргын орлогч Г.Эрдэнэцэцэг Эрүүл мэндийн яамны Төрийн нарийн бичгийн дарга Д.Очирбат тэргүүтэй төлөөлөгчдийг хүлээн авч уулзсан байна. Уулзалтын үеэр "Элэг бүтэн Монгол" үндэсний хөтөлбөр болоод эрүүл мэндийн чиглэлээр аймгийн хэмжээнд хийгдэж буй ажлууд,цаашид хийж хэрэгжүүлэх ажлын талаар харилцан санал солилцжээ.

ЗАЛРУУЛГА

"Монголын мэдээ" сонины 2017 оны 6 дугаар сарын 19-ны даваа гарагийн №118 (4732) дугаарын IV нүүрт нийтлэгдсэн Зөвлөх үйлчилгээний тухай зарлалд дурдсан битүүмжилсэн материал хүлээж авах хугацааг 2017 оны 6 дугаар сарын 27-ны өдрийн 17.30 цагаас өмнө гэж залруулж байна.

ДОКТОРЫН ЗЭРЭГ ХАМГААЛНА

Үндэсний Батлан Хамгаалахын Их Сургууль (ҮБХИС)-ийн докторант А.Ганбат "Хууль бус зэвсэгт бүлэглэлтэй тэмцэхэд Хуурай замын цэргийн анги, салбарыг ашиглах нь" сэдвээр цэргийн ухааны докторын зэрэг хамгаална. Хамгаалуулах зөвлөлийн хуралдаан 2017 оны 7 дугаар сарын 04-ний өдрийн 14:00 цагт ҮБХИС-ийн "Их эе" танхим (Хичээлийн I байрны 306 тоот)-д болно.

БАТЛАН ХАМГААЛАХ, АЮУЛГҮЙ БАЙДЛЫН ДОКТОРЫН АЖИЛ ХАМГААЛУУЛАХ ЗӨВЛӨЛ

ӨДРИЙН СУРВАЛЖЛАГА

АЖИЛ ХАЙЖ БАЙВАЛ ТӨВ ТАЛБАЙГ ЗОРИОРОЙ

Н.БАТЗАЯА

Манай улсад энэ оны тавдугаар сарын байдлаар бүртгэлтэй 28.5 мянган ажилгүй иргэд бий гэх судалгааг Үндэсний статистикийн хорооноос гаргажээ. Ажилгүйдэл ихсэхтэй зэрэгцээд ядуурал, архидалт, нийгмийн эмх замбараагүй байдал нэмэгддэг. Үүнтэй холбогдуулан Засгийн газар болон холбогдох яамнаас ажлын байрыг нэмэгдүүлэх, залуусыг ажилд зуучлах, хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн эрх тэгш байдлыг хангаж, ажлын байраар хангах зэрэг бодлого баримтлан ажиллаж буй. Тэгвэл өчигдөр Сүхбаатарын талбайд олон хүнийг урт дараалалд оруулсан нэгэн үйл ажиллагаа болж өндөрлөлөө. Тодруулбал, Хөдөлмөр нийгмийн хамгааллын яамны харьяа Эрүүл мэнд, нийгмийн даатгалын ерөнхий газар, Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газар болон ажил олгогч аж ахуйн нэгж байгууллагууд хамтран иргэдийг ажлын байранд бүртгэж, хэрэгтэй зөвлөгөө мэдээллийг өгөв. Уг "Нээлттэй хаалга"-ны өдөрлөг 21 аймагт нэгэн зэрэг зохион байгуулагдсан бөгөөд 60 орчим аж ахуйн нэгж 20 мянган ажлын байранд иргэдийг бүртгэж байлаа. Төв талбай өчигдөр ажилд орох хүсэлтэй, өөрт тохирох ажлаа хайж яваа иргэдийн хөлд дарагдсан гэхэд болно. Зарим нэг нь хүссэн ажлын байраа олоод гарч байхад нас хэтэрсэн гэнэ халаглан зогсох хүмүүс ч байсныг нуух юун. Гэхдээ энэхүү өдөрлөг ажил хайж байгаа залуусын цаг завыг хэмнэсэн, тэднийг хүссэн ажилд нь түргэн шуурхай зуулчилсан үр дүнтэй өдөрлөг болсон гэдгийг иргэд онцолж байв.

Иргэдийг үнэ төлбөргүй сургалтад бүртгэлээ

Нээлттэй хаалганы өдөрлөгийн нэгэн онцлох зүйл нь үнэ төлбөргүй сургалт. Өөрөөр хэлбэл, өдөрлөгийн үеэр Нийслэлийн Залуучуудын хөгжлийн газар, БНСУ-ын Хамтын ажиллагааны байгууллага Койкагийн санхүүжилттэй төслийн гүйцэтгэгч "Эм Кэй Ай Ти" сургалтын төвтэй хамтран хөдөлмөр эрхлэх боломцоог нэмэгдүүлэхээр "Мэдээллийн технологийн сургалтын төв"-д үнэ төлбөргүй суралцах хүсэлтэй иргэдийг бүртгэсэн юм. Энэ үеэр Нийслэлийн Залуучуудын хөгжлийн газрын дарга С.Сүх-Очир "Энэхүү сургалтын төв залуучуудыг богино хугацаанд мэдээллийн технологийн салбарт мэргэшүүлж, сурган, олон улсын зах зээлд өрсөлдөх чадвартай боловсон хүчин бэлтгэх зорилготой. Тиймээс компьютерын өргөн хэрэглээний программын сургалтаас гадна "JAVA" хөгжүүлэгч, вэб хөгжүүлэгч, вэб дизайн, систем администратор, өгөгдлийн сан зэрэг нарийн мэргэжлийн зургаан төрлийн сургалтыг үнэ төлбөргүй явуулна" гэв. Мөн өдөрлөгийн хүрээнд Улаанбаатар хот болон хөдөө орон нутгаас ирсэн иргэд, даатгуулагчдад Эрүүл мэнд, нийгмийн даатгалын зээл дэх нийлүүлэлт ихэссэн. Тийм учраас их, дээд сургуулиа төгссөн ихэнх залуучууд ажилд оръё гэсэн ч олдохгүй байгаа юм. Энэ судалгааг хийх хэрэгтэй. Үүний дараа хөдөлмөрийн зах зээлийн эрэлт, нийлүүлэлт тэнцвэртэй хадгалагдаад явах боломжтой юм. Бид энэ ажлыг эхлүүлсэн. Манайд мэргэжлийн боловсролын үндэсний зөвлөл гэж бий. Уг зөвлөлд яамдын төрийн нарийн бичгийн дарга нар байдаг. Энэ нь цаашид ажиллах хүчний эрэлт, хэрэгцээг тодорхойлоход өндөр ач холбогдолтой.

А.Бэхбат: МСҮТ–ийг төгсөгчдийн таван хувь нь шууд ажилтай болдог

/ХХҮЕГ-ын Мэргэжлийн боловсролын бодлогын хэрэгжилтийн газрын дарга /

-Мэргэжлийн сургалт үйлдвэрлэл, политехникийн коллежид ирсэн.

М.Сэлэнгэ: Хоёр газарт анкет бөглөсөн

/Иргэн/

-Би хоёр газарт анкет бөглөлөө. "Скайтел" компани болон Баянгол дүүргийн хөдөлмөрийн халамжийн үйлчилгээний хэлтэст бүртгүүлсэн. Би сургуулиа 2014 онд төгссөн юм. Түүнээс хойш хоёр жил ажилласан. Одоогоор ажилгүй гэртээ байгаа. Тиймээс энэ өдөрлөгийг зорьж ирсэн юм. Сүүлийн үед залуучууд цалин хардаг болсон юм шиг санагдсан. Шууд л 700-800 мянган төгрөгийн цалин авахыг боддог. Гэхдээ зарим нь тэр хэмжээний мэдлэгтэй байж чаддаггүй. Ер нь ихэнх залуус цалингаа голоод ажил хийдэггүй байх. Энэ өдөрлөг их таалагдлаа.

Б.Нямдаваа: Хөдөлмөрийн зах зээлийн эрэлт, нийлүүлэлтийг тэнцвэржүүлэх судалгаа шаардлагатай

/ХХҮЕГ-ын дарга/

-Монгол Улсын хөдөлмөрийн зах зээлийн эрэлт, нийлүүлэлт алдагдсан гэж ярих болсон. Тодруулбал, дээд боловсролтой, дипломтой ажилгүйчүүд ихэслээ гэж ярьж байна. Энэ нь хөдөлмөрийн зах зээлийн эрэлт, нийлүүлэлт алдагдсантай холбоотой. Гэхдээ хөдөлмөрийн зах зээлийн эрэлт, нийлүүлэлт алдагдах болсон шалтгааныг анагаахын салбараар жишээ авч үзье. Манай улсад ойрын хугацаанд нарийн мэргэжлийн хэдэн эмч хэрэгтэй талаар судалгаа алга. Үүнийг БСШУС-ын яамтайгаа хамтарч гаргасан байх ёстой. Судалгаагүй болохоор зах газраас бүх төрлийн үйлчилгээ авах боломжийг бүрдүүлсэн нь олны талархлыг хүлээж байлаа. Өдөрлөгт оролцсон иргэдэд хүүхдийн зуслан, "Элэг бүтэн монгол" хөтөлбөрийн талаархи мэдээллийг хүргэсэн юм. Өдөрлөг өнөөдөр үргэлжилнэ. Энэ үеэр бид холбогдох мэргэжилтнүүдтэй цөөн хором ярилцлаа.

Н.Алтанчимэг: Ажилд бүртгүүлэхээр ирсэн.

/Иргэн/

-Өнөөдөр талбай дээр 20 мянган ажлын байранд иргэдийг зуучилна гэсэн зарын дагуу ирлээ. Их үр дүнтэй өдөрлөг болж байна. Одоогоор ажил олгогч байгууллагатай эхнээс нь танилцаад явж байна. Би сургууль төгсөөгүй. Гэхдээ өөртөө таарсан оёдолчин, туслах зэрэг ажил хайхаар нийт 40 мянган оюутан суралцаж байна. Улсын хэмжээнд төрийн болон төрийн бус өмчийн 90 сургууль үйл ажиллагаагаа явуулдаг. Мэргэжлийн сургалт үйлдвэрлэлийн төвд суралцсан оюутнуудын 50 орчим хувь нь ажлын байртай төгсдөг. Зарим дүүрэгт 60-70 хувь нь ажлын байртай байна. Зарим газарт 40 орчим хувьтай байх жишээтэй. Их, дээд сургууль төгссөн залуучуудын ихэнх нь дипломтой ажилгүйчүүд болсон талаар ярьж байна л даа. Гэтэл манай мэргэжлийн сургалт үйлдвэрлэлийг төгссөн оюутнууд шууд ажлын байранд зуучлагддаг. Өөрөөр хэлбэл, төгсөөд мэргэжлээрээ ажилд орж байна гэсэн үг. Манай сургуулийг жилд 10 мянган оюутан төгсдөг. Түүний тав орчим хувь нь шууд ажлын байртай болдог.

П.Мөнхчулуун:10 орчим ажлын байранд залуусыг бүртгэнэ

/"Манду Хаус" компанийн гүйцэтгэх захирал/

-Манай компани яамнаас зохион байгуулдаг нээлттэй хаалганы өдөрлөгт хоёр дахь удаагаа оролцож байна. Манай компани Азийн уламжлалт хоолыг орчин үеийн үйлчилгээний стандартад нийцүүлэн гаргаж дэлхий нийтэд санал болгож буй Монголын үйлчилгээний брэнд юм. Бид долдугаар сарын 1-нээс "Манду Хуас" сүлжээ рестораныхаа хоёр шинэ салбарыг нээхээр төлөвлөсөн. Энэ хүрээнд залуучуудыг ажлын байранд бүртгэж байна. Тухайлбал, технологич, тогооч, чимхэгч, илдэгч, касс, угаагч, үйлчлэгч гэх мэтчилэн ажлын байранд бүртгэнэ. Бид Монгол Улсын Хөдөлмөрийн хуульд заасны дагуу ажлын найман цагтай. Бусад компаниас ялгарах онцлог гэвэл, хамт ажиллах багийнхантайгаа тохироод ажлын цагаа өөрсдөө зохицуулах боломжтой. Ер нь сүүлийн үед хүний нөөцийн хөгжлийн чиг хандлага өөрчлөгдөж байна. Урьд нь диплом, голч дүнг хардаг байлаа. Одоо харин хүн талаас нь харах болж. Тухайн хүн хэр зөв хандлагатай, зөв хүн бэ гэдгийг ажил олгогчид чухалчилж байна.

УЛС ТӨР

ЕРӨНХИЙЛӨГЧИЙН СОНГУУЛЬ-2017

Г.БАЯРСАЙХАН: НИЙГМИЙН ШИНЭЧЛЭЛИЙГ Х.БАТТУЛГА ХИЙЖ ЧАДНА ГЭДЭГТ БИ ИТГЭДЭГ

Сонгуулийн сурталчилгаагаа Их Эзэн Чингис хааны өлгий нутаг Хэнтий аймгаас эхлүүлсэн Ерөнхийлөгчийн сонгуульд АН-аас нэр дэвшигч Х.Баттулгын мөрийн хөтөлбөрөө танилцуулсан 21 дэх аймаг нь Сэлэнгэ байлаа. Үндсэндээ 12 хоногийн дотор 21 аймгаа нар зөв тойрч, Ардын хувьсгалын өлгий нутаг Сэлэнгэ аймагт хамгийн сүүлд зочилсон нь тэр. Тэгвэл Сэлэнгэ аймаг дахь түүний иргэд, сонгогчидтой хийсэн уулзалтад УИХ-ын гишүүн, УИХ дахь АН-ын бүлгийн дарга Д.Эрдэнэбат оролцож, үг хэлж, нэр дэвшигч Х.Баттулгыг дэмжихийг Сэлэнгэ нутгийн ард иргэдэд уриаллаа. Тэрбээр "Нутгийнхаа зон олныхоо энэ оройн амар амгаланг айлтгая. Баттулга бол энгийн л эр хүн. Бид түүнийг Тулгаа, Женко гэж дууддаг. Хүн хамгийнхаа дотно хүмүүсийг л ингэж авгайлдаг. АН, Ардчилал, Баттулга гурав нэг хувь заяатай юм. Энэ хувь заяа Монгол орны Ардчиллын баталгаа. Би үүнд итгэлтэй байдаг. Ардчиллын үнэлэмж унаж байгаа энэ үед бид хамгийн хариуцлагатай сонголтын өмнө тулж ирээд байна. Алдах эрхгүй сонголт болчихоод байна аа, иргэд ээ. МАН-ын жилийн өмнө амалж байсан бүхнийг та бүхэн санаж байгаа. Ард түмнийхээ итгэл рүү ус цацсан юм шиг зүйл олныг хийснийг та бүхэн мэднэ. Тэд 2016 онд ямар сайхан амалж, гарч ирлээ. АН-ыг хэчнээн их бузар булайгаар нь дуудаж байлаа. Ердөө ганцхан жилийн өмнө шүү дээ. Тэгэхэд Монголын ард түмэн юуг ойлгоогүй вэ. Энэ эрх баригчид дунд чинь бурхны хувцас өмссөн чөтгөрүүд олон байжээ гэдгийг л ойлгоогүй байхгүй юу. Үүнд л би их харамсаж байгаа.Тийм ээ, тэд энэ сонгуульд ялах гэж үзэж байна. Манай нэр дэвшигчээс эхлээд АН-ыг Монгол Улсыг сүйрүүлсэн гэсэн сөрөг сурталчилгааг зогсоо зайгүй хийж байгааг бид харж буй. Хүнд алдах, онох үе байж л байдаг. Гэхдээ Монгол хүн гэж, эх оронч, эрэмгий, баялаг бүтээгч, эзэн хүн гэж хэн бэ гээд та нар бүсдаасаа асуугаарай. Тэгэхэд л энэ асуултын хариулт олдоно. Тийм учраас Баттулга Ерөнхийлөгч болно. Түүнд итгэж байгаа олон мянган монголчууд байгаа" хэмээн хэлж, амжилт хүссэн юм. Улмаар үргэлжлүүлэн, өчигдөр Чингэлтэй дүүргийн иргэд сонгогчидтойгоо уулзаж, мөрийн хөтөлбөрөө танилцууллаа. МҮЭСТО-д болсон энэхүү уулзалтад нэр дэвшигчээс гадна УИХ-ын гишүүн, АН-ын дарга С.Эрдэнэ, Нийслэлийн АН-ын дарга Д.Баттулга, Чингэлтэй дүүргийн АН-ын дарга Г.Баярсайхан тэргүүтэй албаны хүмүүс оролцлоо. Уулзалтыг нээж Чингэлтэй дүүргийн АН-ын дарга Г.Баярсайхан үг хэлсэн бөгөөд тэрбээр "Өнөөдрийн цаг үе биднээс баатрыг нэхэж байна. Ерөөс аль ч цаг үед ард түмнийг оройлох, хөтлөх, зөв удирдах баатар хэрэгтэй байдаг. Тэгвэл тэр баатар нь манай намаас нэр дэвшиж буй Халтмаагийн Баттулга мөн гэдэгт би итгэлтэй байна. Монголын ард түмэн, газар шороотой нь хамт худалдчихжээ, тэд. Үүнийг хүлээн зөвшөөрч болохгүй ээ. Энэ бол Чингис хааны бидэнд үлдээсэн, цаашид мөнх байж, Монголынхоо ард түмний төлөө үеийн үед ажиллаж байх ёстой төр.

Тэгвэл төрийг арилжиж байгаа энэ шударга бус зүйлийг зогсоож чадах хүн бол Халтмаагийн Баттулга гэж би бодож байна. Нөгөө хоёр нь чадахгүй ээ. Хүсэхгүй. Би энэ хүнтэй хамт хоёр ч удаа парламентад хамт суусны хувьд сайн мэднэ. Хийсэн ажлаас нь цухас дурьдая. Энэ хүний хийсэн бүтээн байгуулалтыг Монголын ард түмэн байтугай дэлхий мэднэ. Цонжинболдогоос авахуулаад олон сайхан хүнсний үйлдвэрийг хөл дээр нь босгож, ажиллуулж авч явж байна. Монголын ард түмний төлөө бүтээн байгуулалт хийж, ажилладаг хүн.

Намайг Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хорооны дарга байхад тэр Хүнс, хөдөө аж ахуйн сайд байсан. Гар нийлж ажиллаж байсан, бид. Бид хамтдаа Хүнсний хуулийг баталж гаргасан. Хөдөө аж ахуйн чиглэлээр маш олон ажлыг хийсэн. Энэ хүнд Монголын төлөө гэсэн сэтгэл, цохилох зүрх байдаг юм. Би Баттулга нэр дэвшигчид хэлье. Энэ танхимд Чингэлтэй дүүргийг төлөөлж чадах ард түмэн сууж байна. Чингэлтэйн ард түмэн таныг нэгээр гаргана аа. Таньд амжилт хүсье. Манай нэр дэвшигч АТОЗ-тэй гэрээ байгуулсан. Хэрвээ Ерөнхийлөгч болбол оффшорт байгаа 17 тэрбум ам.долларыг Монголд буцааж авчирна. Эс чадвал би огцорно гэсэн эр зоригтой шийдвэрийг гаргасан байна. Ийм л зоригтой, зоригготой ажилладаг хүн. Энэ хүн шинэчлэгч. Монголын нийгэмд шинэчлэл юу юунаас илүү хэрэгтэй байгаа. Тиймээс нийгмийн шинэчлэлийг Халтмаагийн Баттулга хийж чадна гэдэгт би гүнээ итгэдэг. Монгол ялна аа" гэлээ. Нэр дэвшигч мөн Бөмбөгөр, Хүчит шонхор, захаар орж худалдаа эрхлэгчидтэй уулзлаа.

> ...Манай нэр дэвшигчээс эхлээд АН-ыг Монгол Улсыг сүйрүүлсэн гэсэн сөрөг сурталчилгааг зогсоо зайгүй хийж байгааг бид харж буй. Хүнд алдах, онох үе байж л байдаг. Гэхдээ Монгол хүн гэж, эх оронч, эрэмгий, баялаг бүтээгч, эзэн хүн гэж хэн бэ гээд та нар бүсдаасаа асуугаарай. Тэгэхэд л энэ асуултын хариулт олдоно. Тийм учраас Баттулга Ерөнхийлөгч болно...

С.Батсүх гавьяат С.Ганбаатартай хариуцлагын гэрээ байгуулжээ

МАХН-аас Монгол Улсын Ерөнхийлөгчийн сонгуульд нэр дэвшигч Сайнхүүгийн Ганбаатар энэ сарын 18-нд ард түмэнтэйгээ хариуцлагын гэрээ байгуулж гарын үсэг зурлаа. Чин Ван Ханддоржийн өргөөнд болсон нээлтийн ёслолд нийслэлийн есөн дүүргийн иргэдийн төлөөлөл оролцож гэрээнд гарын үсэн зурсныг Монголын нотариатчдын төлөөлөл гэрчилж баталгаажуулав. Гэрээ байгуулсан иргэдийн төлөөлөлд урлаг соёлын олон алдартнууд байсан. Түүний нэг нь ард түмэндээ Завханы хэмээн алдаршсан С.Батсүх байлаа. Тэрбээр "Эх орон газар шорооныхоо төлөө тэмцэж буй С.Ганбаатарыгаа дэмжиж байна. Манай урлагийнхан ч энэ хүнийг дэмжих хэрэгтэй. Бид эх орныхоо ирээдүйн төлөө зөв сонголтыг хийх цаг нь иржээ" гэж байлаа. Түүнтэй хамт Монгол Улсын Хөдөлмөрийн баатар М.Чимгээ, БГД-ийн иргэн Хөдөлмөрийн баатар Б.Эрдэнэчимэг, "Камертон" хамтлагийн дуучин Л.Ган-Эрдэнэ зэрэг улс орондоо хийж бүтээсэн зүйлтэй алдартнууд ирж нэр дэвшигчтэй хариуцлагын гэрээ байгуулаа.

ЖАНЖНЫ ДҮҮРГИЙНХЭН оюунлаг сонголт хийнэ

МАН-аас Ерөнхийлөгчид нэр дэвшигч М.Энхболд төрийн хөтөлбөрөө иргэд, сонгогчиддоо танилцуулах ээлжилт уулзалтаа нийслэлд үргэлжлүүлж байна. Тэрбээр нийслэл Улаанбаатар хотын зүрхэнд орших, Хөдөлмөрийн гавьяаны улаан тугийн одонт Сүхбаатар дүүргийн иргэд, сонгогчтой уулзаж, захиас даалгавар авлаа. Монгол Улсын тусгаар тогтнол, эв нэгдлийн төлөө тэмцэж явсан их жанжин Д.Сүхбаатараар овоглодог энэ дүүрэг 130 гаруй мянган хүн амтай. Тэдний төлөөлөл АСА циркэд дүүрэн цуглаж, М.Энхболдыг дэмжихээ илэрхийллээ. Нэр дэвшигч эхнэртэйгээ хамт нийслэлийн нэгдүгээр арван жилийн дунд сургуулийг 1982 онд төгссөн бол түүний аав, ээж хоёр мөн энэ сургуулийг 1952 онд дүүргэжээ. Мөн хүү, охин хоёр нь ч уг сургуулийг төгссөн. Ийн гурван үеэрээ эрдэм ном сурч, дээд боловсрол эзэмшиж сууриа нэгдүгээр сургуулиас тавьсан талаараа дурслаа. Төрөлх сургуулийн багш нар болон үе үеийн төгсөгчид нь ч түүнийг дэмжихээр уулзалтад хүрэлцэн иржээ. Энэ дүүргийнхний итгэлийг хүлээж, УИХ-ын гишүүнээр сонгогдсон Д.Цогтбаатар уулзалтын эхэнд М.Энхболд Ерөнхийлөгч болохын давуу талыг онцолж, Ерөнхийлөгч болоод нийслэлийн дахин төлөвлөлтөд анхаарал хандуулахыг хүслээ. Мөн энэ дүүргээс сонгогдсон УИХ-ын гишүүн, Гадаад харилцааны сайд Ц.Мөнх-Оргил нэр дэвшигчтэй есөн настайдаа анх танилцсанаас хойш 40 гаруй жил нөхөрлөжээ. Миеэгомбын Энхболд энэ хугацаанд нэг л зангаараа, нэг л янзаараа яваа нь эрхэт чанар гэдгийг тодотгосон юм. Тэрбээр гаднынхан биднээс нэгдсэн бодлого, эв нэгдэл, тууштай, тогтвортой төрийн үйл ажиллагаа хүсдэг учир төрийн гурван өндөрлөг нэг нэгнийх байснаар энэ нөхцөл бүрдэнэ хэлээн онцлов. Уулзалтын үеэр иргэд байр сууриа илэрхийллээ.

С.Ваанчиг: Хийрхэлд автахгүйгээр сонголтоо зөв хийгээрэй

-Би Монгол Ардын Намд элсээд 80 гаруй жил болж байна. Энэ хугацаанд миний итгэлийг алдаж байгаагүй учир залуус минь эртнээс сайн мэдэх, улс төрийн ууган хүчнээ дэмжээрэй. Хийрхэлд автахгүйгээр сонголтоо зөв хийгээрэй. Миеэгомбын Энхболд бол төлөв төвшин зантай, төр засагт олон жил ажилласан. Ийм л хүн төрийн тэргүүн болох ёстой. Ахмадууд биднийг ач санах хуультай болгож, жилд хоёр удаа урамшуулал олгодог болсонд баярлаж явдаг.

Г.Тэрбиш: Буух эзэнтэй, буцах хаягтай уугуул намын хүнээ дэмжинэ

-Монгол Улс төрийн тэргүүнээ сонгох хариуцлагатай үед тулж ирлээ. Нэр дэвшигчид уран цэцэн, гоё сайхан ярих нь гол биш. Хэрэв энэ хүн Ерөнхийлөгч болбол миний, бидний төлөө юу хийх билээ, мөрийн хөтөлбөрөө хэрэгжүүлж чадах уу, улс орноо гадаад төлөөлж чадах уу гэдгийг юун түрүүнд бодох хэрэгтэй. Сонгуульд сэтгэлийн хөөрлөөр хандаж болохгүй. Би Монгол Ардын Намаас нэр дэвшигч Миеэгомбыг дэмжиж байна. Сүүлийн үед улс төрийн намууд тарж бутардаг, эсвэл шуудайд хийсэн үхрийн эвэр шиг талцаж муудалцдаг болсон. Тиймээс буух эзэнтэй, буцах хаягтай уугуул намын хүнээ дэмжинэ.

Үүний дараа Миеэгомбын Энхболд "Монгол төр-Монгол гэр" мөрийн хөтөлбөрөө танилцуулав. Сүхбаатар дүүргийнхэн хөдөлмөрч, мэдлэг боловсролыг дээдэлдэг оюунлаг ард түмэн. Тиймээс ам ажлын нэгдэлтэй, аливаад авах гээхийн ухаанаар ханддаг, эрдэм боловсролтой Миеэгомбын Энхболдыгоо дэмжиж, Ерөнхийлөгчөөр сонгоно гэдгээ жанжны дүүргийнхэн онцоллоо.

Реклам, зар сурталчилгааны алба: 99173710

ДЭЛХИЙ

Киргизийн экс Ерөнхий сайд сонгуульд нэр дэвшинэ

Киргизстан улсын “Ак-Шумкар” улс төрийн намын тэргүүн, Ерөнхий сайд асан Темир Сариевыг Киргиз улсын Ерөнхийлөгчийн сонгуульд нэр дэвшүүлжээ. Энэ тухай өчигдөр тус намын улс төрийн зөвлөлөөс “Бүс нутаг бүрээс хүрэлцэн ирсэн төлөөлөгчид Т.Саривыг бараг зуун хувийн саналаар тус улсын Ерөнхийлөгчийн сонгуульд нэр дэвшүүллээ” хэмээн мэдээлсэн юм. Түүнчлэн, “Ойрын хугацаанд зохих бичиг баримтуудыг бүрдүүлэн Т.Сариевыг төрийн тэргүүний сонгуульд нэр дэвшигчээр албан ёсоор бүртгүүлэхээр Киргизийн Сонгуулийн төв комисст шилжүүлэн өгнө” гэж мэдэгдэлдээ дурьдсан байна. Т.Сариев 2015-2016 онд Киргизстан улсын Ерөнхий сайдаар ажилласан бөгөөд энэ хугацаанд улсаа Евразийн эдийн засгийн холбоонд элсүүлэхэд идэвхтэй оролцдог байжээ. Улмаар түүний хичээл зүтгэлээр Киргиз 2015 оны наймдугаар сард тус холбоонд элсч байсан аж. Тус улсын дараагийн Ерөнхийлөгчийн тодруулах сонгууль ирэх аравдугаар сарын 15-нд болно. Одоогийн байдлаар, Сонгуулийн төв комист “Лига-антикризис” олон нийтийн байгууллагын Ерөнхийлөгч Назарбек Нышанов, сөрөг хүчний улстөрч, “Ата-Мекен” социалист намын тэргүүн Омурбек Текебаев нар өрсөлдөхөөр бүртгүүлжээ. Киргиз улсын хуулиар төрийн тэргүүнийг зургаан жилийн хугацаагаар зөвхөн нэг удаа сонгодог учир өнөөгийн Ерөнхийлөгч нэр дэвших боломжгүй юм.



Э.МАКРОНЫ ЯЛАЛТ ҮРГЭЛЖИЛСЭЭР...

Б.ДАВАА

Францын Ерөнхийлөгчийн сонгуульд хэний ч мэдэхгүй намын нэр дэвшигч ялалт байгуулсан билээ. Байгуулагдаад ердөө нэг жил болж буй шинэхэн улс төрийн хүчнээс нэр дэвшсэн Эммануэль Макрон зөв менежмент ашиглан сонгуулийн сурталчилгаагаа явуулж, үр дүнд нь Францын Ерөнхийлөгч болсон. Ийнхүү Францын улс төрд “шинэ од” мэндэлсэн юм. Тэгвэл түүний ялалтын буухиа үргэлжилсээр байна.

Энэ сарын 11-нд тус улсын парламентын доод танхимын эхний шатны санал хураалт болж, Макроны төвийн үзэл баримтлалт ““La Republique En Marche” нам болон түүний холбоотон болох төвийн үзэл баримтлалт улс төрийн хүчин “Mo-Dem” нийтдээ 32.32 хувийн дэмжлэг авч, олонх болох нь нэгэнт тодорхой болсон удаатай. Харин Францын эрх баригч хүчин болох Социалистууд энэ сонгуулиар 200 суудлаа алдахаар байсан юм. Тэгвэл парламентын доод танхимын шийдвэрлэх шатны сонгууль өнгөрөгч амралтын өдрүүдэд болж, Э.Макроны шинэхэн нам олонх боллоо. Францын парламентын доод танхим болох Үндэсний ассамблей 577 суудалтай, Үндэсний ассамблейн сонгуулийг хоёр үе шаттайгаар явуулдаг. Өнгөрсөн 12-ны өдөр болсон эхний шатны сонгуульд Макроны нам мөн л ялалт байгуулсан юм. Хоёр дахь шатны сонгуульд эхний шатаар 50 хувийн санал авч чадаагүй сонгуулийн тойрогт санал хураалт болсон. Хоёр дахь шатанд орохын тулд, эхний шатанд дор хаяж 12.5 хувийн санад авах ёстой байдаг. Санал хураалт орон нутгийн цагаар өглөөний 08:00 цагт эхэлж, орой 18:00 цагт хааж, санал тоолох ажил эхэлсэн. Энэ удаагийн сонгуульд 18 сая орчим иргэн саналаа өгснөөс нийт сонгогчдын 48 хувь нь буюу 8.7 сая иргэн Ерөнхийлөгч Макроны намд саналаа өгчээ. Ингэснээр түүний нам нийт үндэсний ассамблейд 350 суудал авсан гэсэн үг юм. Энэ удаагийн сонгуульд анх удаа оролцож ялалт байгуулсан буюу бидний хэлдгээр “бор халзан хонь”-ууд олон байгааг ч хэвлэлүүд онцолж байна.

Мөн анх удаа 200 гаруй эмэгтэй нэр дэвшигч ялалт байгуулсан нь Францын орчин үеийн түүхэнд шинэ амжилт боллоо. Шинээр бүрэлдэх үндэсний ассамблейд харьцангуй залуу, бас янз бүрийн арьсны өнгө бүхий нэр дэвшигчид сонгогдсоноос гадна эмэгтэйчүүдийн тоо дээр дурьдсан хэмжээнд хүртлээ нэмэгдсэн нь 1958 оны тав дахь Бүгд найрамдах Засаглал, тэр ч байтугай 1945 оны Францын ардчилалыг бэхжүүлсэн үетэй харьцуулахад томоохон эргэлж болж байна.

Макроны намын гол өрсөлдөгчид болох Францын хэт барууны үзэл баримтлагч Марин Ле Пены нам 135 суудал авсан бол социалист нам 45 суудал авчээ. Сонгуулийн дүн сүүлийн 10 жилийн турш эрх барьсан намуудад томоохон цохилт болсныг олон улсын хэвлэлүүд онцолж байна.

Лондонд дахин халдлага гарлаа

Их Британийн нийслэл Лондон хотод дахин халдлага гарлаа. Халдлага шөнө дундын үед буюу 00.20 цагийн үед гарчээ. Тодруулбал, тус хотын хойд хэсэгт орших лалын шашны сүмийн гадна мөргөлчдийг автомашинаар дайрсан байна. Тухайн үед иргэд шөнийн мөргөл үйлдэхэд гарч явсан бөгөөд тэр үед нь микро автомашин тэднийг дайрсны улмаас нэг хүн амь үрэгдэж, долоон хүн гэмтэн эмнэлэгт хүргэгджээ. Цагдаагийн алба хаагчид гэмт хэрэгтнийг саатуулсан байна. Лалын шашинтнуудын рамадан сар эдүгээ үргэлжилж буй. Үүнтэй холбоотойгоор лалын шашинтнууд шөнийн мөргөл үйлдэг аж. Гэрчүүд баривчлагдсан хүнийг “цагаан арьстай, эрэгтэй хүн” байсан гэжээ. Сүмийн орчим харуул хамгаалалтыг нэмэгдүүлээд байна.

“Seven Sisters Road” гудамжны ойролцоох энэхүү сүм нь нэгэн үе лалын радикал үзлийн нэг гол төв болж байжээ. Гэвч сүүлд удирдлага нь солигдож, бүхэлдээ шинэчлэгдсэн юм байна. Өмнөх имам (сүмийн тэргүүн санваартан) Абу Хамза 2015 онд терроризмийн хэргээр Нью Йоркод бүх насаар хоригдох ял авсан юм.

Тэрбээр 1997-2003 онд энэ сүмийн имамаар ажиллаж байгаад бусдыг хүчирхийлэлд уриалсан хэргээр баривчлагдаж байжээ. Дараа нь Абу Хамзаг АНУ-д шилжүүлж өгсөн юм байна. Хэдийгээр сүмийн удирдлагын явуулж байгаа энх тайванч бодлогын ачаар нийгмийн хандлага өөрчлөгдсөн ч Европт гарсан террорист халдлага бүрийн дараа тус сүмд сүрдүүлсэн захидал, имэйл ирдэг байжээ.Энэ сарын эхээр Лондон хотын гүүрэн дээр мөн ийм төрлийн халдлага гарсныг лалын радикал үзэлтнүүд үйлдсэн юм.

Долоон цэргийн цогцсыг олжээ

АНУ-ын тэнгисийн цэргийн “USS Fitzgerald” хөлөг онгоц Филиппиний тээврийн “ACX Crystal” хөлөгтэй мөргөлдөж, гурван хүн гэмтэж, долоон хүн нас барлаа. Албаныхан өчигдөр мэдэгдэл хийж, сураггүй болсон долоон хүний цогцсыг олсон тухайгаа мэдээллээ. Осол Япон тэнгист Ёокосүка боомтоос баруун урагш 100 км зайд орон нутгийн цагаар 02:00 цагийн үед гарсан байна. АНУ-ын Тэнгисийн цэргийн аврах бие бүрэлдэхүүн хөлөг онгоцыг ням гарагийн орой олж, онгоцны гэмтсэн хэсгээр дамжин орж, далайчдын цогцсыг гарган авчээ. USS Фитжералд онгоц бямба гарагт Иокосүка боомтоос баруун өмнөд тийш орон нутгийн цагаар 17:30-ийн үед хөдөлсөн байна. Гэвч, шөнө дундын үед далайн мандалд урагшилж явахдаа хөлөг онгоцтой мөргөлдөж, их биеийн орчимд ихээхэн гэмтэл авсан байна. NHK телевизийн мэдээлснээр осол болох үед хөлгийн багийнхан бүгд унтаж байжээ. АНУ-ын тэнгисийн цэргийн алба хаагчид золгүй тохиолдлоор амиа алдсан нь анхны тохиолдол гэдгийг хэвлэлүүд онцолж байна. Нас барсан залуус 19-37 насныхан байжээ.

Голланд нисдэг машин үйлдвэрлэж байна

АНУ-ын “The Jetsons” гэх хүүхэлдэйн киноноос эхлээд Их Британийн “Chitty Chitty Bang Bang” гэх мюзикл хүртэлх янз бүрийн төрөл жанрын кинонд тэнгэрээр сүлжилдэн нисэх автомашины тухай өгүүлдэг билээ. Нэг талаар, энэ нь олон жилийн турш хүн төрөлхтөний мөрөөдөлболсонунааюм.Тэгвэл бодит байдалд ийм төрлийн машин тун удахгүй биеллээ олох бололтой. Орчин үед олон улс ирээдүйд нисдэг машин бүтээх төслийг хөгжүүлж, судалж байгаа. Гэхдээ хамгийн анхны загварыг нь Голланд үйлдвэрлэж магадгүй байна.

Олон жилийн турш туршилтын нислэг хийж буй Голландын “Pal-V” компани өрсөлдөгчдөөсөө урьтахаар зэхэж буй гэнэ. Тус компани дэлхийн хамгийн анхны хоёр хүний суудалтай, гурван дугуйтай машиныг үйлдвэрлэж байна. Голландын Рамсдонксвир хотод төвтэй “Pal-V” компани 2018 оны сүүлч гэхэд анхны нисдэг машинаа олон нийтэд танилцуулах төлөвлөгөөтэй ажиллаж байна.

Уг машиныг хөлөглөхийн тулд жолоочид жолооны болон нисгэгчийн үнэмлэхний аль аль нь шаардлагатай бөгөөд түлхүүрээ түлхээд нисэх зурвас хүртэл машинаа жолоодож, улмаар дээш хөөрөх гэнэ. Дээш хөөрч зохих өндрийг авсны дараа урагшилсаар зорилтот цэгтээ хүрэх юм байна. Мөн машиныг 100 морины хүчин чадалтай хос хөдөлгүүрээр тоноглосон бөгөөд хийгээр ажиллах аж. Машин дээш 3500 метрт хөөрөх хүчин чадалтайн зэрэгцээ, 400-500 км замыг туулах чадвартай гэнэ. Харин хурдны тухайд 170 км/ц. “Pal-V” компанийн мэдээлснээр 2019 он гэхэд 50-100 яг ийм машиныг зах зээлд нийлүүлэхээр төлөвлөж буй аж. Гэхдээ сонирхож буй хүмүүс дуулгахад, үнийн хувьд тийм ч хямд биш байх бөгөөд 299-499 мянган евро хүрч магадгүй байна.

МУБИС-д багш шалгаруулж авна

БАГШИЙН СУРГУУЛЬД:

- Сурган сэтгэл судлалын багш -1
- Хөгжим арга зүйн багш -2

БОЛОВСРОЛ СУДЛАЛЫН СУРГУУЛЬ:

- Сэтгэл судлалын багш -1

УРЛАГ, БИЕИЙН ТАМИРЫН СУРГУУЛЬ:

- Хөгжмийн онолын /гармони/ багш-1
- Найрал дууны багш -1
- Сагсан бөмбөгийн мэргэжлийн багш-1

тус тус шалгаруулж авна.

ТАВИГДАХ ЕРӨНХИЙ ШААРДЛАГА:

Монгол улсын төрийн болон гадаадын их дээд сургуулиудыг магистр болон түүнээс дээш зэрэгтэй төгссөн, ерөнхий боловсролын сургууль болон их дээд сургуулиудад багшилж байсан туршлагатай, судалгааны арга зүй эзэмшсэн, гадаад хэл (англи, орос, болон бусад), сурган хүмүүжүүлэх ухаан, боловсрол судлалын зохих мэдлэгтэй, мэдээлэл харилцааны технологийн хэрэглээний чадвар эзэмшсэн, багаар ажиллах чадвартай, оюутнуудтай харилцах эв дүйтэй, бүтээлч сэтгэлгээтэй, боловсролын шинэчлэлд нээлттэй, тогтвор суурьшилтай ажиллах, багшийн ёс зүйг сахидаг байх.

Бүртгэл: *2017 оны 06 дугаар сарын 19-23-ныг дуустал МУБИС-ийн 1-р байрны /хуучнаар А байрны/ 108 тоотод явагдана.*

БҮРДҮҮЛЭХ МАТЕРИАЛ:

- CV монгол хэлээр
- Бакалавр, магистр докторын дипломын баталгаажуулсан хуулбар
- Төрийн албан хаагчийн анкет
- Ажил байдлын тодорхойлолт
- Иргэний үнэмлэхний баталгаажуулсан хуулбар
- Цээж зураг 3 хувь /3*4/
- Нийгмийн даатгалын дэвтэр, эрүүл мэндийн дэвтэрийн хуулбар
- Шалгалтын хураамж 20.000 төгрөг тус тус авч ирнэ үү

ШАЛГАЛТ: 2017 оны 06 дугаар сарын 26-30-ны өдрүүдэд дараах чиглэлээр явагдана.

Үүнд:

1 Эхний ярилцлага
2 Мэргэжлийн шалгалт
3 Гадаад хэл /Англи, орос болон бусад хэл/
4 Мэдээлэл харилцаа технологийн хэрэглээний чадвар
5 Боловсрол судлалын орчин үеийн асуудлууд
6 Нэгдсэн ярилцлага

Жич: *Тухайн шалгалтандаа тэнцээгүй ажил горилогчийг дараагийн шатны шалгалтад оролцуулахгүй бөгөөд хураамжийг буцаан олгохгүй болохыг анхаарна уу*

Холбогдох утас: 311547, 99957309
Хөтөлбөрийн нэгдсэн алба

МЭДЭЭЛЭЛ

АЛБАНЫ ХҮНИЙ ҮГ

Д.ДАВААДОРЖ: “Тогтвортой бичил уурхай” төслийн бичил уурхай дахь сайн туршлагууд журам шинэчлэгдэхэд их үр дүн өгсөн

Үргэлжлэл.
Түрүүч нь I нүүрт

Мөн журамд орсон нэг том өөрчлөлт бол аймаг, нийслэлийн Засаг даргын эрх, үүргийг нэмж оруулсан бөгөөд аймаг, нийслэлийн Засаг дарга тухайн аймаг, нийслэлийг хөгжүүлэхэтийнзорилттойгоо уялдуулан бичил уурхайн бүсчилсэн төлөвлөгөө гаргаж, төлөвлөгөөний дагуу ажиллана гэсэн үг. Мөн аймгаас нэгдсэн удирдлагаар хангаж, хяналт тавьж ажиллах нь хариуцлагын тогтолцоог нэмэгдүүлэх бөгөөд Засгийн газраас аймаг, нийслэлийн Засаг дарга нартай шууд харьцах нь хариуцлагыг нэмэгдүүлнэ гэж үзэж байгаа.

-Шинэчлэгдсэн журам гарснаар бичил уурхай эрхлэгчдийн эрхзүйн орчин нэлээд сайжирсан байх?

-Анх журам гарсан зорилго нь тухай орон нутгийн ажилгүй иргэдэд тодорхой хэмжээний ажлын байр бий болгож, орлогыг нэмэгдүүлж, ядуурлыг бууруулахад чиглэж байсан, одоо ч энэ нь хэвээрээ юм. Том уурхайгаас ялгаатай бөгөөд бичил уурхайд их хэмжээний орлого, ашгийн тухай ярьдаггүй. Хуулийн хүрээнд нөхөрлөл, хоршооны зохион байгуулалтад орж ажиллах нь тухайн орон нутгийн ажилгүй иргэдийн хувьд нийгмийн халамж, хамгаалал, төрийн үйлчилгээг авах эхний алхам болно гэдгийг бичил уурхай эрхлэх хүсэлтэй иргэд маш сайн ойлгох хэрэгтэй бөгөөд журмын бас нэг зорилго юм.

-Бичил уурхайчдыг үнэмлэхжүүлэх асуудал яригдаж байна. Үнэмлэхжүүлснээр ямар үр дүн гарна гэж үзэж байгаа вэ?

-Тухайн сумын Засаг дарга бичил уурхайн ажилтнуудад үнэмлэх олгохоор журам, дүрмээр зохицуулж өгсөн байгаа. Үнэмлэх олгосноор тухайн орон нутагт бүртгэлтэй бичил уурхайн нөхөрлөл, хоршооны зохион байгуулалтад орсон иргэд хууль ёсны дагуу үйл ажиллагаа явуулж байгаа нөхцөлд ямар нэгэн хяналт, шалгалтын үед тухайн талбайд ажиллахад ямар нэгэн айх юмгүй ажиллана гэсэн үг. Нөгөөтэйгүүр үнэмлэх авснаар бүртгэлд хамрагдаж нийгмийн халамж, үйлчилгээ авах нөхцөл бүрдэж, албан ёсны бичил уурхайн ажилтан болно.

-Бичил уурхай эрхлэгчид нөхөрлөл, хоршооллын бүтцэд орж ажиллаж байгаа. Энэ хэрээрээ тоног төхөөрөмжийн хүчин чадал нь нэмэгдэж байгаа юу?

-Дээр дурьдсан зөвхөн нөхөрлөл, хоршооны зохион байгуулалтад орсон нь тоног төхөөрөмж ашиглаж болно. Бүртгэгдээгүй нөхөрлөлийн хувьд боломжгүй.

-Бичил уурхай эрхлэгчид өөрсдөө ашигт малтмал олборлох газраа сонгох ёстой юу?

-Нөхөрлөл, хоршоо нь тухайн талбайд бичил уурхайгаар ашигт малтмал олборлох өргөдлөө сум, дүүргийн Засаг даргадаа гаргах бөгөөд тухайн талбайн талаарх мэдээллийг сум, дүүргийнхээ Засаг даргын тамгын газраас авч болно. Шаардлага хангасан өргөдлийг сум, дүүргийн Засаг дарга судалж үзээд аймаг, нийслэлийн Засаг даргад хүргүүлнэ. Аймаг, нийслэлийн Засаг дарга тухайн жилийн аймаг, нийслэлийн бичил уурхайн бүсчилсэн төлөвлөгөөтөй уялдуулан Ашигт малтмал, газрын тосны газарт талбайн дүгнэлт гаргуулахаар ирүүлэх бөгөөд бичил уурхайгаар ашиглах боломжтой гэсэн дүгнэлт гарсан тохиолдолд тухайн талбайг бичил уурхайн зориулалтаар орон нутгийн тусгай хэрэгцээнд авах эсэхээ аймаг, нийслэлийн ИТХ-аар хэлэлцүүлж, шийдвэрлэхээр журамласан байгаа.

> ...Маш зөв асуулт байна. Хуучин орлогыг нь тухай бүр тодорхойлох боломжгүй ажил үйлчилгээ хувиараа эрхлэх иргэний албан татварын тухай хуулиар бичил уурхай эрхлэгчид сар бүр 53 мянган төгрөгийн татвар төлдөг байсан хэдий ч энэ хууль нь 2016 оны нэгдүгээр сарын 01-нээс хүчингүй болсон...

-Тэдэнд тавигддаг нэг чухал асуудал бол нөхөн сэргээлт. Нөхөн сэргээлтийн ажлыг хэр хийж байна?

-Энд нэг зүйлийг тодруулан хэлье. Зохион байгуулалтад орсон бичил уурхайчид болон хууль бусаар хувиараа ашигт малтмал олборлогч хоёр бол зарчмын тэс ондоо ойлголт. Өнгөрсөн хугацаанд зохион байгуулалтад орсон бичил уурхайчид маань нийт 220 га талбайд нөхөн сэргээлт хийсэн гэсэн дүн мэдээ бий. Ер нь уул уурхайн үйл ажиллагааны улмаас эвдрэлд орж эзэнгүй орхигдсон талбайг хууль бус буюу бидний хэлдгээр “нинжа” нар эвдэж, орхиж явсан байдаг. Түүнээс хуулийн хүрээнд үйл ажиллагаа явуулдаг тусгай зөвшөөрөл эзэмшигчид хуулийн дагуу, бичил уурхайчид гэрээний үүргийнхээ дагуу техникийн болон биологийн нөхөн сэргээлтийн ажлыг хийж гүйцэтгэдэг. Хуулийн хэрэгжилтийг хангахын тулд орон нутгийн удирдлага, мэргэжлийн хяналтын байгууллага тогтмол хяналт тавьж ажиллах зайлшгүй шаардлагатай байдаг. Бичил уурхайгаар ашигт малтмал олборлох журмын хувьд сум, дүүргийн Засаг даргатай гэрээ байгуулахын өмнө нөхөн сэргээлтийн төлөвлөгөөг тухайн сум, дүүргийн байгаль орчны улсын хяналтын байцаагчаар хянуулан, Засаг даргаар батлуулж хавсаргах бөгөөд энэ нь гэрээний салшгүй нэг хэсэг байхаар зааж өгсөн. Нөхөн сэргээлт хийгээгүй тохиолдолд гэрээ цуцлах, дахин тэр нөхөрлөл, хоршоотой гэрээ байгуулахгүй.

-Бичил уурхай эрхлэгчидтэй байгуулсан гэрээ цуцлагдсан ч нөхөн сэргээлтийг хийлгэж, хүлээж авах уу?

-Гэрээ цуцлах нь нөхөн сэргээлт хийх үүргээс чөлөөлөхгүй бөгөөд энэ талаар журамд болон гэрээний загварт нарийн тусгасан. Гэрээ байгуулахын өмнө нөхөн сэргээлтийн дундын санд нөхөн сэргээлтийн зардлыг төвлөрүүлсэн байх ёстой. Хэрвээ ямар нэгэн байдлаар орхиод явсан тохиолдолд тухайн сум, дүүргийн Засаг дарга нөхөн сэргээлтийн дундын санд төвлөрүүлсэн хөрөнгөөр нөхөн сэргээлтийг гүйцэтгэнэ.

-Түүнчлэн бичил уурхайчид ашигт малтмал олборлож, тодорхой хэмжээний орлого олж байгаа. Тэд улсад татвар төлдөг үү?

-Маш зөв асуулт байна. Хуучин орлогыг нь тухай бүр тодорхойлох боломжгүй ажил үйлчилгээ хувиараа эрхлэх иргэний албан татварын тухай хуулиар бичил уурхай эрхлэгчид сар бүр 53 мянган төгрөгийн татвар төлдөг байсан хэдий ч энэ хууль нь 2016 оны нэгдүгээр сарын 01-нээс хүчингүй болсон. Ашигт малтмал олборлож тодорхой хэмжээний орлого олж байгаа иргэд хувь хүний орлогын албан татварын тухай хуулийн дагуу төлж, иргэнийхээ үүргийг биелүүлэх ёстой. Мөн нөхөрлөл, хоршооны хувьд аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуулиар татвар төлөх шаардлагатай.

-Мөн бичил уурхай эрхлэгчид олборлосон алтаа заавал нийслэлд авч ирж, Монголбанкинд тушаах эсвэл ченжүүдэд өгөх гэсэн хоёр сонголттой байдаг. Энэ нь тэдэнд их хүндрэлтэй байдаг юм шиг санагдсан. Үүнийг зохицуулж байгаа юу?

-Журамд олборлосон ашигт малтмалыг хууль тогтоомжийн дагуу борлуулахаар тусгасан, мөн тусгай зөвшөөрөл эзэмшигчийн талбайд гурвалсан гэрээгээр үйл ажиллагаа явуулж байгаа тохиолдолд ашигт малтмалыг борлуулахдаа тухайн тусгай зөвшөөрөл эзэмшигчийн нэр дээр бүртгүүлэхээр зааж өгсөн.

-Орон нутагт төв банкны салбар байсан ч сорьцын асуудал тулгарах нь дамжиггүй. Энэ асуудлыг хэрхэн шийдвэрлэж байгаа вэ?

-Алт худалдан авах нэг цэгийн үйлчилгээг төвлөрсөн аймаг, суманд байгуулахаар Стандартчилал, хэмжил зүйн газрын Сорьцын хяналтын албатай хамтран ажиллаж байна.

-Өнгөрсөн хугацаанд Монголбанкинд алт тушаах иргэдийн тоо нэмэгдэж байгаа юу. Зарим хүмүүсийн ярьж байгаагаар аж ахуйн нэгжүүд татвараас зугтааж, иргэнээр тушаадаг гэж ярьдаг. Энэ үнэхээр байдаг асуудал уу?

-Өнгөрсөн жилийн Монголбанкинд тушаасан алтны 60 гаран хувь нь иргэдээр тушаагдсан байдаг. Ашигт малтмалын тухай хуулиар тусгай зөвшөөрөл эзэмшигч нь үнэт металл, эрдэнийн чулуур Монголбанкны эрдэнэсийн санд худалдах үүрэгтэй байдаг бөгөөд Монголбанк, түүнээс эрх олгосон банкинд хуралдсан алтанд ашигт малтмалын нөөц ашигласны төлбөрийн хэмжээ 2.5 хувь байдаг. Тусгай зөвшөөрөл эзэмшигч нь иргэнээр Монголбанкинд алтаа тушааж байх магадлалтай, бид энэ асуудлыг судалж байгаа.

-Швейцарийн хөгжлийн агентлагийн хэрэгжүүлж буй “Тогтвортой бичил уурхай” төсөл маш үр дүнтэй байгаа гэсэн. Энэ талаар ярьж өгөхгүй юу?

-ШХА-тай хамтран хэрэгжүүлж байгаа “Тогтвортой бичил уурхай” төсөл 2005 оноос өнөөдрийг хүртэл амжилттай хэрэгжиж байгаа. Бичил уурхайн талаар эрх зүйн орчны асуудлыг шийдвэрлэхэд техникийн болон санхүүгийн туслалцаа үзүүлж ирсэн. Энэхүү журмыг шинэчлэн боловсруулахад тэдний бичил уурхай дахь сайн туршлагууд их үр дүнгээ өгсөн гэж боддог.

САЙН МЭДЭЭ

Монгол Улсын тэргүүлэх салбарынхан АЛТАН ЖОЛООЧУУД

Худалдааны салбарт үйл ажиллагаагаа эхлүүлж байсан үндэсний хэмээх тодотголтой “Алтан Жолоо” групп эдүгээ үйлдвэрлэл үйлчилгээ, барилга импорт, худалдаа гээд нэлээд хэдэн салбарт үйл ажиллагаагаа явуулж байна.

Анхны үйл ажиллагааны чиглэл болох худалдааны салбарын үйл ажиллагаа тухайн цаг үедээ цөөн байсан үйлчилгээний төв буюу 59-р дэлгүүрээс эхлэлтэй бөгөөд нэн шинэ үеийн худалдааны салбарын түүхийг эхлүүлэн бичилцэж яваа гэж хэлж болно.

Ийнхүү олон салбарт хүнээ дэмжлэн нийгмийн хариуцлагаа биелүүлэн ажиллаж байгаа Алтан Жолоо группын спортын наадам гурван өдрийн турш болж өндөрлөлөө. Уламжлал болон зохиогддог энэхүү наадам 25 жилийн ойн нэрэмжит болон зохион байгуулагдсанаараа онцлог байлаа.

Энэхүү спортын наадамд оролцогчид дөрвөн төрөлд 80 багц медалийн төлөө оюун ухаан хурд хүчээ сорин өрсөлдсөн төдийгүй нэг ажилтан Монголын Үндэсний Олимпийн Хорооны дээд шагнал болох “Алтан Очир” одонгоор шагнагдаж, хоёр ажилтан “Спортын мастер” цолоор шагнагдлаа.

Мөн Монголдоо болон Олон улсын чанартай тэмцээний зохион байгуулалтад туушгай ивээнтэгж, спортын хөгжилд бодитой хувь нэмэр оруулж буйд Монголын Хөлбөмбөгийн Холбоо, Монголын Үндэсний Бөхийн Холбооны удирдлагууд болон Монголын Үндэсний Олимпийн Хорооны төлөөлөл ирж талархал илэрхийлэн баяр хүргэлээ.

Тэмцээний нээлтэд урлаг спортын ододуригдаж холимог оддын нөхөрсөг тоглолтыг хийж сонирхолтойгоор эхлүүллээ. Ийнхүү группын хамт олны догдлон хүлээдэг “Алтан Жолоо” группын спортын наадам 25 жилийн ойн хүрээнд өрсөлдөөнтэй ялагдал ялалтын нулимстай, яригдах дурсамж дүүрэн болж өндөрлөлөө.

Реклам, зар сурталчилгааны алба: 99173710

ЗАВСАРЛАГА

Улаанбаатарт:

Маргааш

Өдөр +18
Шөнө +14

Нөгөөдөр

Өдөр +17
Шөнө +6

Өдрийн зурхай

ЗУНЫ ТЭРГҮҮН ХӨХӨГЧИН МОГОЙ САРЫН НАЙМАН ЦАГААН МЭНГЭТЭЙ ХАР БИЧ ӨДӨР

Үс засуулбал:
Жаргал үргэлжид ирнэ

Наран ургах, шингэх:
04.54-20.51

Тухайн өдөр морь, нохой жилтнээ аливаа үйлийг хийхэд эерэг сайн ба бич, тахиа жилтнээ сөрөг муу нөлөөтэй тул элдэв үйлд хянамгай хандаж, биеэ энхрийлүүштэй. Эл өдөр худалдаа арилжаа хийх, бизнэс эхлэх, хүү сангийн эх хатгах, эд агуурс авах, зээл авах, арвижуулах, дэлгэрүүлэх үйлийг эхлэх, хараал, жатхыг буцаах, амьлуулах, өглөгийн түллэг хийх, хишиг дуудуулах, хот балгадын үйл, цэрэг, цагдаагийн үйл, гэр, байшингийн суурь тавихад сайн. Золиг гаргах, бомбын үйл, бэрийн үйлд муу. Өдрийн сайн цаг нь хулгана, үхэр, луу, могой, хонь, нохой болой. Хол газар яваар одогсод хойш мөрөө гаргавал зохистой. Үс шинээр үргээлгэх буюу засуулбал жаргал үргэлжид ирэх сайн.

Бидэнд тохиолдсон хүндхэн хөгтэй явдлуд

Уранчимэг Магванчамба

Цуг ажилдаг найзуудаасаа сонсож байлаа. Манай байгууллагад нэг залуу ажилд орж л дээ. Гадаадад олон жил болсон болохоор зарим монгол үгээ мартсан юм шиг байгаа юм. Нэг удаа хонины гулууз мах авсанаа ярьж л дээ. Гулууз мах гэж хэлэх гээд юу гэхээ мэдэхгүй суниагаад хөлдсөн юм уу, давхиж байгаад хөлдсөн юм уу мэдэхгүй тийм хонины мах авсан гэж ярьсан гэсэн гэнэ лээ. Хаха

ЗАГВАРЫН ЕРТӨНЦ

Л.ЗУЛ:
Энэ зун шар өнгийг зоригтой сонгож болно

Г.ГАНЧИМЭГ

"Dew brand"-ийг үүсгэн байгуулагч, загвар зохион бүтээгч Л.Зултай энэ зуны загварын трэнд, өнгөний сонголт болон акссесуарын талаар ярилцлаа

-Энэ зуны загварын чиг хандлага дэлхийд ямар байгаа юм бол. Эндээс хоёулаа ярилцлагаа эхлэе?

-Энэ зун хувцас загварт атлас, торгон материал түлхүү орж ирж байгаа. Атлас, торгон материалыг унтлагын хувцас, үдшийн даашинзанд хэрэглэдэг байсан бол одоо өдөр тутмын хувцсанд оруулдаг болжээ. Деталь хэлбэрийн хувьд мөрөө гаргасан загвар, мөн нэг мөрөө гаргасан загвар, босоо болон хөндлөн гээд төрөл бүрийн судлууд энэ зуны трэнд байх болно. Тиймээс 70, 80-аад оны судалтай трапецан өмд эргээд моод болж байгаа. Энэ зун 80-аад оны өргөн мөртэй пиджакаар ч гангарч болно гээд ер нь 70, 80-аад оны моод загварын ертөнцөд эргэн ирж байгаа юм. Цагаан өнгийн богино даашинз ч энэ зуны топ гоёо болно. Мөн цацган чимэглэл, бүсэн дээрээ нугалаа хуниастай загвар ч моодноос гарахгүй. Үүн дээр нэмээд топ танк буюу нарийн мөртэй майкнууд 2016 онд ч трэнд байсан. Энэ жил ч трэнд хэвээрээ байна.

-Уналттай, зөөлөн торгомсог материалтай хэр нь 70, 80-аад оны загварын илүү сайжруулсан хувилбарууд энэ зуны трэнд байх нь гэж ойлголоо. Харин ямар өнгө моодонд орох бол?

-Тодоосоо бүдэг хүртэлх бүх төрлийн ягаан өнгө дэлхийн загварын ертөнцөд трэнд болж байгаа. Тэгээд шар өнгийг нэрлэж болно. Хүмүүс шар өнгийн хувцсыг "Хэтэрхий хурц байна", "Тод өнгө" гээд өмсөхөөс зайлсхийдэг. Харин энэ зун ингэж айхгүй өмсч болно. Мөн цэцгэн хээ, геометрийн дүрс, мөнгөлөг өнгө ч моодноос гарахгүй.

-Гэхдээ монголчуудын хувьд ихэнх нь хөрслөг бор арьстай учраас шар өнгө төдийлөн зохидоггүй. Тиймээс ихэнх нь шар өнгөнд дуртай биш гэдэг нь анзаарагддаг. Харин монголчуудын хувьд ямар өнгийг трэнд болгохоо наадмын гоёогоороо л харуулах байх даа?

-Орчин үед зөвхөн дизайнер гэлтгүй залуучууд маань хувцас загварын өргөн мэдлэгтэй болжээ. Яагаад гэвэл сошиал ертөнцөөр дамжуулан бүх дэлхийн мэдээллийг маш хялбархан, өөртөө дөхөм аргаар авч байна шүү дээ. Одоо цагт энгийн иргэн хүртэл мэргэжлийн загвар зохионбүтээгчээсдутахааргүймэдлэгтэй, дэлхийн трэндийг дагаж хувцасладаг болчихсон байна. Орчин үеийн залуучууд дэлхийн трэндээс хоцрохгүй хэр нь өөрийн хувь хүний онцлог, үзэл бодлоо ч хувцаслалтаараа илэрхийлдэг болжээ. Өдөр тутмын хувцаслалтандаа дэлхийн трэндийг "street style"-тай маш чадмаг хослуулдаг болсон байна. Ялангуяа, манай охид маш өндөр мэдрэмжтэй нь анзаарагддаг. Тиймээс залуучуудын хувцаслалтыг харахад ерөнхийдөө трэнд болсон өнгүүдийг маш гярхай олж харж, хувцас загвартаа ашиглаж байна.

-Та загвар зохион бүтээгч хүн учраас иймэрхүү зүйлийг их гярхай ажигладаг байх. Гэхдээ "Моод Монголоор дуусдаг" гэдэг үг бий. Зарим нь "Үгүй, моод Монголоор эхэлдэг" хэмээн сөргүүлдэг л дээ. Ер нь энэ зун монголчууд дэлхийн загварын трэндээс юуг нь илүү анзаарч хувцас загвартаа шингээж байна вэ?

-Монголчууд нүүдэлчдийн өвөрмөц соёл, эдлэл хэрэглэлтэй. Үүнийгээ дагаад хувцас загвар нь өөрийн гэсэн онцлогтой юм. Үндэсний хувцсаа орчин цагт ямар л бол ямраар хөгжүүлж байгаа. Бид жилдээ хоёрхон удаа монгол дээл, үндэсний хувцсаа өмсдөг байлаа. Харин сүүлийн жилүүдэд зөвхөн Цагаан сар, баяр наадам гэлтгүй үндэсний хувцсаа өмсдөг болжээ. Бүр өдөр тутмын загваруудад хүртэл үндэсний хувцасны загварын деталь түлхүү орж ирж байна. Европ загварын хувцсанд ч монгол зах, хээ угалз, үндэсний хэв маягийг шингээж өгдөг болжээ. Биед эвтэйхэн эсгүүртэй, үндэсний онцлогийг тусгасан загварыг өдөр тутамдаа өмсч байна.

-Судлан дээрх цэцгэн хээ хэдийнэ гудамжны загварын трэнд болсон нь анзаарагдсан. Мөн Ерөнхийлөгчийн сонгуульд нэр дэвшигчдийн гэргий, охин цэнхэр өнгийн дээл, даашинз сонгож, нээлтийн ёслолдоо өмссөн нь энэ наадмын дээлний өнгийг тодорхойлчих шиг болсон. Энэ зун "Наадмаар цэнхэр торгон дээл өмнө" гэх хүн олон болжээ?

-Монголын томооохон загварын төлөөлүүд принттэй даавууг хувцас загвартаа өргөнөөр ашигласан байна лээ. Энэ жилийн зуны загварт маш нимгэн материалтай, зөөлөн өнгөнүүд зонхилж байгаа. Тодруулбал, гэрэлтсэн шифонон материалтай сул чөлөөтэй загваруудд моодонд орж байна. Дэлхийд трэнд болсон өнгөнүүд Монголд хүчээ авч байгаа.

-Та наадмын загвартаа ямар өнгийг түлхүү ашиглав. Таны санаачлан үүсгэн байгуулсан "Dew brand"-ийн хоёр дахь коллекц бэлэн болж байгаа юм билээ?

-Бүх төрлийн ягаан өнгийг ашигласан. Мөн зөөлөн өнгүүдийг уусгаж өгсөн нь энэ жилийн трэндтэй нэгдэж байгаа. Материалын хувьд силк, атласан материалыг коллекцдоо оруулсан. Миний зохион бүтээдэг хувцасны онцлог гэвэл 100 хувийн силкэн дээр гараар зурж хийдэг учраас олноор принтэлж болдоггүй, зөвхөн тухайн хүндээ зориулагдсан дахин давтагдашгүй гоёмсог загвар болдог. Зуны загварын коллекцдоо энэ бүхнээ тусгаж дээл, цамц, майк урласан. Мөн алчууртай нь хослуулж хийсэн байгаа.

-Алчуур гэснээс акссесуар хувцаслалтыг иж бүрэн болгож, дуусгаж өгдөг гэдэг. Тэгвэл энэ зуны трэнд нь алчуур уу, зүүлт үү гээд яг юу байх вэ?

-Өнгөрсөн жил чокёр моодонд орж байсан бол энэ зун чокёроос арай том хэмжээтэй, нарийн хийцтэй, гоёмсог зүүлтнүүд трэнд болж байгаа. "Dew brand"-ийн хувьд акссесуараа маш энгийнээр шийдсэн. Яагаад гэвэл, хувцас маань маш эмзэг материалтай, нарийн ажиллагаатай. Силк, шифон материалыг оёход маш хэцүү байдаг. Овор хэмжээ багатай, жижиг ээмэг зүүхэд л болно. Мөн шифон, силкэн дээр гараар зурсан хээтэй гоёмсог ороолт, алчуурыг хослуулан бүтээсэн байгаа.

-Загвар зохион бүтээгчдийг бүхэл бүтэн улирлын трэндийг тодорхойлж гаргаж ирэх гэж багагүй хугацаанд сэтгэл оюунаа чилээж, ур чадвараа шавхдаг гэдгийг ойлгож байна. Гэхдээ хэрэглээн дээр бүх хүн 90х60х90 байдаггүй. Гэтэл та бүхэн дандаа ийм хэмжээтэй хувцас урлах юм. Яагаад гэдгийг загвар зохион бүтээгчтэй уулзсаных асуучихъя?

-Загвар зохион бүтээгчид шинэ коллекц, тухайн улирлын трэндээ гаргачихаад загварын шоу зохион байгуулдаг. Үүнийг нь үйлдвэрүүд үзээд худалдаж авдаг юм л даа. Гэхдээ бүх загварыг авах албагүй. Нэг деталийг авсан ч болдог. Тайзны хувцасны загвар, өнгө, деталь зэргээс аль нэгийг нь сонгон авч хялбарчлаад өдөр тутмын хувцсанд шингээж үйлдвэрлэх процесс явагддаг юм. Монголд ч адилхан, ийм л байгаа. Тухайлбал, би дандаа нэг размерийн хувцас хийсэн байгаа. Гэхдээ үүнийг хувилж олшруулах хэцүү л дээ. Яагаад гэвэл, миний урласан хувцас 100 хувийн силкэн дээр дандаа гараар зурдаг учраас нарийн ажиллагаа, их цаг хугацаа шаардаг. Дахин давтагдашгүй гэдэг утгаараа ч олон тоогоор гардаггүй. Гэхдээ хүссэн хүн ямар ч размерээ захиалаад хийлгэх боломжтой.